



**АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

65130 Цэцэрлэг, Архангай аймаг
Утас/Факс: 976-70333141
И-мэйл: arkhangai@audit.gov.mn

2023.04.19 № 163

танай _____-ны № _____-т

**ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН
САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗАРТ**

Архангай аймаг дахь Төрийн аудитын газар нь Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.7-д заасны дагуу аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн нэгтгэсэн тайлан, нэгдсэн төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайланг хүргүүлж байна.

Хавсралт ... хуудастай.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  Т.БАЙГАЛМАА



АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



АРХАНГАЙ АЙМГИЙН ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧИЙН 2022 ОНЫ НЭГТГЭСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

Аудитын код:
АРА-2023/01/НА-СТА-ТЕЗ

Архангай аймаг дахь Төрийн аудитын газрын
дарга, Тэргүүлэх аудитор Т.Байгалмаа
Утас: 7033-3141
Цахим хаяг: Baigalmaat@audit.gov.mn

Аудитын менежер Д.Нэргүйбаатар
Утас: 7033-2860,
Цахим хаяг: Nerguibaatard@audit.gov.mn

Ахлах аудитор Н.Алтантуяа
Утас: 99338611
Altantuyan@audit.gov.mn

ЦЭЦЭРЛЭГ ХОТ
2023 он

Тайланг хянасан:	АГУУЛГА
Архангай аймаг дахь Төрийн аудитын газар	ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР.....3
Дарга, тэргүүлэх аудитор Т.Байгалмаа	ҮНДСЭН МЭДЭЭЛЭЛ.....8
Аудитын менежер Д.Нэргүйбаатар	1.1 ОРОН НУТГИЙН ОРЛОГЫН ТӨЛӨВЛӨЛТ10
Тайланг бэлтгэсэн: Ахлах аудитор Н.Алтантуяа	1.2 ОРОН НУТГИЙН ОРЛОГЫН ГҮЙЦЭТГЭЛ..... 12
2023 оны 04 дүгээр сар	2.1 ОРОН ТӨСВИЙН ЗАРЛАГЫН ТӨЛӨВЛӨЛТ.....16
Уг тайланг Үндэсний Аудитын газрын Вэб сайт-аас үзнэ үү. www.open.audit.mn	2.2 ОРОН ТӨСВИЙН ЗАРЛАГЫН ГҮЙЦЭТГЭЛ..... 18
Аудитын тайлан, дүгнэлттэй холбоотой асуудлаар нэмж тодруулах асууж лавлах зүйл байвал 70332860, 70333019 дугаарын утас, 70333141 дугаарын факсаар харилцана уу,	2.3 ТӨРИЙН ХЭМНЭЛТИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТ.....26
Хаяг: Архангай аймаг дахь Төрийн аудитын газар Аймгийн ЗДТГ- ын байр	3.ТЕЗ-ИЙН ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТ.....28
	4.НЭМЭЛТ САНХҮҮЖИЛТ.....29
	5. ӨМНӨХ ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТ29
	6.ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧИЙН НЭГДСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ.....31
	АУДИТЫН ДҮГНЭЛТ.....33
	АУДИТЫН ЗӨВЛӨМЖ.....34
	УЛАМЖЛАХ САНАЛ34

Товчилсон үгийн тайлбар

АДОУС	Аудитын дээд байгууллагуудын Олон улсын стандарт
ААН	Аж ахуй нэгж
ААНОАТ	Аж ахуй нэгжийн орлогын албан татвар
УСНББОУС	Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
ГХБХБГ	Газрын харилцаа барилга хот байгуулалтын газар
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
ОНӨХХК	Орон нутгийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компани
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
СТСХ	Санхүү төрийн сангийн хэлтэс
ХХС	Хоршоо хөгжүүлэх сан
ТЭЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ТШЗ	Төсвийн шууд захирагч
ҮАГ	Үндэсний аудитын газар
ТАГ	Төрийн аудитын байгууллага
ТҮ	Төрийн үйлчилгээ

Тайлан баталгаажуулсан тушаал



АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН ТУШААЛ

2023 оны 04 сарын 19 өдөр

Дугаар 9/2022

Цэцэрлэг

Тайлан баталгаажуулах тухай

Монгол Улсын Ерөнхий аудиторын 2018 оны А/207 дугаар тушаалын 5 дугаар хавсралтын 2 дугаар зүйлийн 2.4 дэх заалт, 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагын акт тогтоох, албан шаардлага өгөхөд баримтлах журам"-ын 7.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Архангай аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2022 оны төсвийн гүйцэтгэл, санхүүгийн нэгтгэсэн тайлан"-д хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг тус тус баталгаажуулсугай.
2. Аудитаас өгөгдсөн зөвлөмж, албан шаардлагыг хавсралтаар баталсугай.
3. "Архангай аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2022 оны төсвийн гүйцэтгэл, санхүүгийн нэгтгэсэн тайлан"-д хийсэн аудитын тайлангуудыг Үндэсний аудитын газар, аймгийн Засаг дарга болон ИТХ-ын даргад тус тус хүргүүлсүгэй.
4. Аудитаар өгөгдсөн зөвлөмж албан шаардлагын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг аудитын менежер (Д.Нэргүйбаатар)-т үүрэг болгосугай.



Т.БАЙГАЛМАА

ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй

Архангай аймаг дахь Төрийн аудитын газар Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1-т заасан бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8.9.4 дэх заалтын дагуу аймгийн 2022 оны төсвийн гүйцэтгэлд аудит хийв.

Аудитын зорилт

Архангай аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2022 оны төсвийн гүйцэтгэлийн тайланг шалгаж, дүгнэлт, зөвлөмж гарган аймгийн ИТХ болон төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлэхэд аудитын зорилт чиглэгдлээ. Уг зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр аудитыг гүйцэтгэлээ. Үүнд:

1. Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2022 оны төсвийн орлогыг бодитой төлөвлөж, төвлөрүүлсэн эсэх
2. Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2022 оны төсвийн зарлагыг үндэслэлтэй төлөвлөж, зориулалтын дагуу үр дүнтэй зарцуулсан эсэх
3. Төсвийн ерөнхийлөн захирагчийн хэрэгжүүлэх хөтөлбөр арга хэмжээний хүрэх үр дүн, зорилтот түвшинд нийцсэн эсэх
4. Нэмэлт санхүүжилтийг зориулалтын дагуу зарцуулсан эсэх
5. Өмнөх аудитаар өгөгдсөн зөвлөмжийг биелүүлж ажилласан эсэх

Аудитын хамарсан хүрээ

Аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2022 оны төсвийн гүйцэтгэлийн тайлан, түүнд нэгтгэгдсэн байгууллагуудын тайлан мэдээ, аймаг, сумдын ИТХ-ын хуралдааны тогтоол, Сангийн яамнаас Архангай аймгийн 2022 оны аймгийн төсвийн суурь, орлого зарлагыг хянаж ирүүлсэн тооцоо, ОНХС, засаг дарга данс, гамшгаас хамгаалах зардал, авто замын сан, халамжийн сан, ТЕЗ-ийн 2022 онд сайдуудтай байгуулсан гэрээ, түүний хэрэгжилт болон бусад судалгаа, материалд тулгуурлан аудитыг гүйцэтгэв.



Аудитын арга зүй

Аудитыг гүйцэтгэхдээ АДБОУС, Төрийн хяналт, шалгалтын стандарт, Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”, 2021 оны А/111 тушаалын 2 дугаар хавсралтаар баталсан “Төрийн аудитын байгууллагаас төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийх аргачилсан зөвлөмж” арга зүйг баримтлан холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, асуулга, лавлагаа болон судалгаа авах, тайлан баримт материалд тулгуурлан харьцуулах, нэгтгэх, дүн шинжилгээ хийх зэргээр аудитын горимын дагуу нотлох зүйл цуглуулж, аудитын дүн, дүгнэлт, зөвлөмж боловсруулав.

Аудитад ашигласан шалгуур үзүүлэлт

Дараах хууль эрхийн актыг аудитын шалгуур үзүүлэлтийн эх сурвалж болгон ашиглав. Үүнд:

- Төсвийн тогтвортой байдлын тухай хууль
- Төсвийн тухай хууль
- Төрийн аудитын тухай хууль
- Монгол Улсын 2022 оны төсвийн тухай хууль
- Татварын багц хуулиуд
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн хэмнэлтийн тухай хууль
- Бусад холбогдох хууль, тогтоомж, журам, зааврууд
- Аймаг сумдын ИТХ-ын тогтоолууд

Аудитын бүрэлдэхүүн, хугацаа

Аудитыг Архангай аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор Т.Байгалмаа хянан удирдаж, аудитын менежер Д.Нэргүйбаатар чанарын хяналтыг хэрэгжүүлж, ахлах аудитор Н.Алтантуяа 2023 оны 04 дүгээр сарын 01-ны өдрөөс эхлэн 2023 оны 04 дүгээр сарын 20-ний өдрийг хүртэлх хугацаанд хийж гүйцэтгэв.

Аудитын тайлангийн бүтэц, түүнд тусгагдсан мэдээлэл, хэлэлцүүлсэн журам

Аудитын тайланг үндсэн мэдээлэл, аудитын дүн, аудитын дүгнэлт, зөвлөмж гэсэн агуулгаар бичиж, аудитын тайланд аудитын менежер, тэргүүлэх аудитор нараар үе шатны хяналт хийлгэж, тайланг аймгийн ИТХ-ын дарга, аймгийн Засаг дарга нарт хүргүүлэв.

ҮНДСЭН МЭДЭЭЛЭЛ



Монгол Улсын Их Хурлаас 2020 оны 12 дугаар сарын 24-ний өдөр баталсан “Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай” хууль болон энэхүү хуулийг дагалдан батлагдсан “Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” хууль 2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс хэрэгжиж эхэлсэн. Хуулийн өөрчлөлтөөр аж ахуйн нэгжийн орлогын албан татварын 40 хувийг орон нутгийн суурь орлогод шилжүүлж, Төсвийн тухай хуулийн 58 дугаар зүйлд заасан орон нутгийн төсвийн суурь зарлагад тооцогддог зарим чиг үүргүүд нь Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль (МУЗЗНДНТУТ)-ийн 27 дугаар зүйлд зааснаар засаг захиргааны нэгжийн удирдлагаар төлөөлөн гүйцэтгүүлэх төрийн чиг үүрэгт шилжсэн байна.

Монгол Улсын 2022 оны төсвийн тухай хуулийг УИХ-ын 2021 оны 11 дүгээр сарын 12-ны өдрийн хуралдаанаар баталсан бөгөөд Архангай аймгийн 2022 оны төсвийн жилийн суурь орлогыг 12,947.1 сая төгрөгөөр, суурь зарлагыг 33,022.3 сая төгрөгөөр, улсын төсвөөс олгох санхүүгийн дэмжлэгийг 20,075.2 сая төгрөгөөр, ОНХС-д олгох орлогын шилжүүлгийг 7,409.6 сая төгрөгөөр, ОНХС-ийн суурь зарлагыг 780.2 сая төгрөгөөр тус тус баталсан байна.

Аймгийн ИТХ-ын 2021 оны 12 сарын 02-ны өдрийн “Аймгийн 2022 оны төсөв батлах тухай” 14 дүгээр тогтоолоор аймгийн төсвийн орлого, зарлагын тэнцлийг **44,918.5** сая төгрөгөөр баталсан ба аймгийн 2022 оны төсөвт 1 удаа тодотгол хийгдэж, Аймгийн ИТХ-ын 2022 оны 06 сарын 06-ны өдрийн “Аймгийн 2022 оны тодотгон төсөв батлах тухай” 11 дүгээр тогтоолоор аймгийн төсвийн орлого, зарлагын тэнцлийг **41,449.3** сая төгрөгөөр буюу анх баталсан төсвөөс **3,469.2** сая төгрөгөөр бууруулжээ.

Хүснэгт: 1 Аймгийн 2022 оны төсвийн тэнцлийн судалгаа

сая төгрөгөөр

Үзүүлэлт	Анх баталсан дүн	Тодотгон баталсан дүн	Зөрүү
Орон нутгийн төсвийн нийт орлого	15,428.9	15,342.2	(86.7)
Улсын төсвөөс авах санхүүгийн дэмжлэг	20,075.2	15,390.5	(4,684.7)
Улсын төсвөөс авах ОНХС-ийн орлогын шилжүүлэг	7,409.6	6,815.9	(593.7)
ОНХС-ийн урьд оны үлдэгдэл	510.0	896.8	386.8
Мал хамгаалах сангийн үлдэгдэл	40.0	40.0	-
Аймгийн урьд оны төсвийн үлдэгдэл	1,454.8	2,963.9	1,509.1
Орон нутгийн орлого, санхүүгийн дэмжлэгийн дүн	44,918.5	41,449.3	(3,469.2)
Сумдын удирдлагын зардал	9,608.5	9,809.4	200.9
Аймгийн удирдлагын зардал	7,339.0	8,928.0	1,589.0
Хот тохижилт үйлчилгээ	401.7	451.2	49.5
Халамжийн сан	122.4	122.4	-
Мал хамгаалах сан	40.0	40.0	-
Орон нутгийн өмчит байгууллагын байр ашиглалтын тогтмол зардал, засвар үйлчилгээ, харуул, хамгаалалт	16,686.9	11,585.3	(5,101.6)
ОНХС	9,617.2	9,410.2	(207.0)
Хөрөнгийн зардал: Их завсар	1,102.8	1,102.8	-
Орон нутгийн зарлагын дүн	44,918.5	41,449.3	(3,469.2)

Аймгийн ИТХ-аар тодотгон баталсан орон нутгийн төсвийн нийт орлого **15,342.2** сая төгрөг сумд өөрсдийн эрх мэдлийн хүрээнд сумын ИТХ-аар **393.5** сая төгрөгийн 9 нэр төрлийн орлого нэмэгдүүлэн нийт дүнгээр **15,735.7** сая төгрөгийн орлого төвлөрүүлэхээр баталжээ. Гүйцэтгэлээр нийт **18,260.9** сая төгрөгийн орлого төвлөрүүлж, төлөвлөгөөг **116.0** хувиар буюу **2,525.2** сая төгрөгөөр давуулан биелүүлсэн байна. Тайлант онд төлөвлөсөн 25 нэр төрлийн орлогоос 16 нэр төрлийн орлогыг **4,549.5** сая төгрөгөөр давуулж, 9 нэр төрлийн орлогын төлөвлөгөөг **2,024.3** сая төгрөгөөр тасалсан байна.

Аймгийн төсвийн нийт зарлага 2022 оны жилийн эцсийн байдлаар **51,675.3** сая төгрөгийн төлөвлөгөөтэйгөөс **42,228.6** сая төгрөг буюу **81.7** хувийн гүйцэтгэлтэй байна. Харин Аймгийн ТЕЗ-ийн нэмэлт санхүүжилтийн дансаар 2022 онд нийт **2,080.1** сая төгрөг зарцуулагджээ.



Улсын төсвөөс авах ОНХС-ийн орлогын шилжүүлгийг төлөвлөсний дагуу **6,815.9** сая төгрөг хүлээн авч, улсын төсвөөс авах санхүүгийн дэмжлэг 15,390.5 сая төгрөгөөс 2022 оны төсвийн тухай хууль, Өрийн удирдлагын тухай хуулийн дагуу төсвийн жилд “Дамжуулан зээлдүүлсэн зээлийн өр төлбөрийг суутган тооцох тухай” Сангийн Сайдын 2022 оны 33 дугаар тушаалын дагуу орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагч нарын ерөнхий орлогын данснаас хугацаа хэтэрсэн өр төлбөрийн дүнгээр тухай бүрд суутган тооцож бүртгэх замаар авлага барагдуулах арга хэмжээ авахаар шийдвэрлэсэн байна.

Үүний дагуу дамжуулан зээлийн төлбөр болох **495.0** сая төгрөгийг суутгуулсан байна. Харин Сангийн яамнаас өгсөн чиглэлийн дагуу улсаас авах санхүүгийн дэмжлэг **15,390.5** сая төгрөгийг бүрэн авч, **495.0** сая төгрөгийг Сангийн яаманд буцаан суутгуулсан байдлаар тайлагнах чиглэлийг ирүүлсний дагуу санхүүгийн тайланг бэлтгэжээ.

Аймгийн ИТХ-ын 2022 оны 6 дугаар сарын 06-ны өдрийн “Аймгийн 2022 оны тодотгосон төсөв батлах тухай” 11 дүгээр тогтоолын дагуу Эрдэнэбулган сумаас аймгийн төсөвт **1,317.2** сая төгрөгийг төвлөрүүлэхээр баталснаас гүйцэтгэлээр **1,090.0** сая төгрөг төвлөрч, төсөвт байгууллагуудын урсгал санхүүжилтэд зарцуулсан байна.

БҮЛЭГ 1. ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ОРЛОГЫН ТӨЛӨВЛӨГӨӨГ 116.0% БУЮУ 2,525.2 САЯ ТӨГРӨГӨӨР ДАВУУЛАН БИЕЛҮҮЛСЭН БАЙНА

1.1 ТӨСВИЙН ОРЛОГЫН ТӨЛӨВЛӨЛТ



Төсвийн ерөнхийлөн захирагч нарын 2022 оны төсвийн төсөл бэлтгэх удирдамжид Орон нутгийн 2022 оны төсвийн орлогын төсөөллийг боловсруулахдаа хүчин төгөлдөр мөрдөгдөж буй төсвийн болон татварын хууль тогтоомжийг мөрдөж, орлогын боломжит эх үүсвэрүүдийг дайчлах, бааз суурийг өргөжүүлэх, нийгэм, эдийн засгийн хөгжлийн зорилтуудыг биелүүлэхэд шаардлагатай санхүүгийн эх үүсвэрийг бүрдүүлэхэд ач холбогдол өгч ажиллах талаар тусгажээ.

Аймгийн 2022 оны орлогын төсвийн төслийг Сангийн Яамнаас ирүүлсэн Төсвийн ерөнхийлөн захирагч нарын 2022 оны төсвийн төслийг боловсруулах удирдамжийн хүрээнд сумдаас ирүүлсэн тооцоолол, татвар ногдох зүйл, газар хэлтсүүдээс ирүүлсэн холбогдох тооцоо судалгааг нэгтгэж мэргэжлийн байгууллагуудын мэргэжил арга зүйд тулгуурлан орон нутгийн төсвийн нийт орлогыг 24 нэр төрлөөр **10,829.5** сая төгрөгөөр боловсруулан Төсвийн тухай хуулийн 8.4.3¹-д заасан хугацаанд Сангийн Яаманд хүргүүлсэн байна.

Сангийн яам 2022 оны төсвийн жилийн суурь орлогыг **2,117.6** сая төгрөгөөр нэмэгдүүлэн **12,947.1** сая төгрөгөөр хянажээ. Томоохон дүнтэй зарим нэр төрлийн орлогыг нэмэгдүүлэн хянасан байдлыг авч үзвэл:

Өмнөх оны гүйцэтгэлд үндэслэн цалин хөлсний орлогын албан татварыг 820.0 сая, хүү торгуулийн орлогыг 450.0 сая, байгалийн нөөц ашигласны төлбөр ойн дагалт самрын орлогыг 300.0 сая төгрөгөөр, Монгол Улсын засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн өөрчлөлтийн дагуу аж ахуй нэгжийн орлогын албан татварын орлогыг 560.0 сая төгрөгөөр нэмэгдүүлэн, харин шууд бус орлогыг өмнөх оны гүйцэтгэлд үндэслэлгүйгээр Сангийн яамнаас 800.0 сая төгрөгөөр хянасан байна.

Орон нутгаас хүргүүлсэн орлогын төсвийн төслийг өмнөх оны төлөвлөгөө, гүйцэтгэл, Сангийн яамны хянасан дүнтэй зэрэгцүүлэн харуулбал дараах байдалтай байна.

Хүснэгт: 2 Орлого төлөвлөлтийн судалгаа

сая төгрөгөөр

ОРЛОГЫН ТӨРӨЛ	2021 он		СЯ-нд хүргүүлсэн 2022 оны санал /суурь/	СЯ-ны хянасан дүн / суурь /	Зөрүү /нэмэгдүүлсэн/
	Төлөвлөгөө	Гүйцэтгэл			
НИЙТ ОРЛОГО	11,444.4	15,189.9	10,829.5	12,947.1	2,117.6
ТАТВАРЫН ОРЛОГО	10,512.7	13,498.7	10,186.0	11,385.0	1,199.0
ТАТВАРЫН БУС ОРЛОГО	916.7	1,601.3	628.5	1,547.1	918.6
ХӨРӨНГИЙН ОРЛОГО	15.0	89.9	15.0	15.0	-

¹ “Төсвийн ерөнхийлөн захирагч жилийн төсвийн саналаа жил бүрийн 8 дугаар сарын 15-ны дотор санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэх”

Хүснэгтээс харахад орон нутгаас хүргүүлсэн 2022 оны суурь орлогын төсвийн санал нь:

1. 2021 оны төлөвлөгөөтэй харьцуулахад 614.9 сая төгрөгөөр буюу 5.3 хувиар,
2. Мөн оны гүйцэтгэлтэй харьцуулахад 4,360.4 сая төгрөгөөр буюу 28.7 хувиар тус тус бууруулж төлөвлөсөн байна.

Өмнөх оны гүйцэтгэл өндөр байгаа нь цалин хөлсний орлогын албан татвар, ойн дагалт самрын орлогоос орлого өндөр дүнгээр давж төвлөрсөнтэй холбоотой байна.

Аймгийн 2022 оны төсвийн суурь орлогыг Сангийн яамнаас **12,947.1** сая төгрөгөөр хянаж ирүүлснийг **Төрийн аудитын газраас өгсөн орлого нэмэгдүүлэх саналын дагуу малын тоо толгойн албан татварын орлогыг 2,327.8 сая, хадгаламжийн хүүгийн орлогыг 132.8 сая, газрын дуудлага худалдааны орлогыг 225.5 сая, төрийн болон орон өмчит хөрөнгө борлуулсны орлогыг 16.4 сая, нийт 2,702.5 сая төгрөгөөр нэмэгдүүлсэн.** Мөн сумдын тухайд орон нутгийнхаа онцлог байдалтай уялдуулан хуулиар эрх олгогдсон эрх хэмжээний хүрээнд 5 нэр төрлийн орлогыг **129.0** сая төгрөгөөр нэмэгдүүлж, 5 нэр төрлийн орлогыг **349.7** сая төгрөгөөр бууруулан аймгийн төсвийн орлого нийт дүнгээр **2,481.8** сая төгрөгөөр нэмэгдэж, төсвийн орлогыг **15,428.9** сая төгрөг болгон аймгийн ИТХ-ын 2021 оны 12 дугаар сарын 02-ний өдрийн “Аймгийн 2022 оны төсөв батлах тухай” 14 дүгээр тогтоолоор баталжээ.

Харин Аймгийн 2022 оны тодотгосон төсөв батлах тухай аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2022 оны 06 дугаар сарын 06-ны өдрийн 11 дүгээр тогтоолоор шууд бус орлогыг **86.7** сая төгрөгөөр бууруулан 2022 оны орон нутгийн төсвийн орлогыг нийт **15,342.2** сая төгрөгөөр баталсан байна.

Аймгийн ИТХ-ын тогтоолоор анх болон тодотгон баталсан төсвийн орлогын дүн дээр сумд дараах орлогын нэр төрлөөр нэмэгдүүлэн төсвийн төлөвлөлтийн фискал программд оруулсан байна. Үүнд :

- Газрын дуудлага худалдааны орлогыг нийт **230.5** сая төгрөгөөр /Хотонт -94.0 сая, Төвшрүүлэх – 136.5 сая/;
- Төсөвт байгууллагын өөрийн орлогыг нийт **88.5** сая төгрөгөөр /Төвшрүүлэх- 3.6 сая, Эрдэнэбулган – 20.0 сая, Хангай-15.7 сая, Эрдэнэмандал-13.7 сая, Цахир – 41.8 сая төгрөгөөр нэмэх, Өндөр-Улаан – 6.3 сая төгрөгөөр хасах /;
- Малын тоо толгойн албан татварын орлогыг **21.1** сая төгрөгөөр /Өндөр-Улаан - 31.3 сая төгрөгөөр нэмэх, Жаргалант-10.2 сая төгрөгөөр хасах /;
- Түгээмэл тархацтай ашиг малтмал ашигласны төлбөр Өндөр-Улаан сум – **27.3** сая төгрөгөөр;
- Ан амьтны нөөц ашигласны төлбөр Цахир сум – **17.0** сая төгрөгөөр ;
- Бусад нэр заагдаагүй орлого Хотонт сум- **7.5** сая төгрөгөөр;
- Үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар Төвшрүүлэх сум – **6.0** сая төгрөгөөр;
- Ус рашааны нөөц ашигласны төлбөр Хотонт сум **-2.0** сая төгрөгөөр тус тус нэмэгдүүлэн,
- Хог хаягдлын хураамжийг 6.4 сая төгрөгөөр / Хангай -1.5 сая нэмэх, Өндөр-Улаан -7.9 сая хасах / хасаж, сумдын төсвийн орлого нийт дүнгээр **393.5** сая

төгрөгөөр нэмэгдэж, аймгийн хэмжээнд орон нутгийн төсвийн нийт орлого **15,735.7** сая төгрөгөөр төлөвлөгдсөн байна.

1.2 ТӨСВИЙН ОРЛОГЫН ГҮЙЦЭТГЭЛ



Орон нутгийн төсвийн орлого гүйцэтгэлээр **18,260.9** сая төгрөг төвлөрч төлөвлөгөө **116.0** хувиар буюу **2,525.2** сая төгрөгөөр давж биелсэн байна.

Орон нутгийн төсвийн орлогын 88.2 хувь нь татварын орлогоос, 11.2 хувь нь татварын бус орлогоос, 0.6 хувь нь хөрөнгийн орлогоос бүрдсэн байна.

Хүснэгт: 3 Орлого төлөвлөгөө, гүйцэтгэлийн судалгаа

сая төгрөгөөр


ҮЗҮҮЛЭЛТИЙН НЭР	ТӨЛӨВЛӨГӨӨ	ГҮЙЦЭТГЭЛ	ЗӨРҮҮ	БИЕЛЭЛТИЙН ХУВЬ
НИЙТ ОРЛОГО	15,735.7	18,260.9	2,525.2	116.0
УРСГАЛ ОРЛОГО	15,704.3	18,151.5	2,447.2	115.6
ТАТВАРЫН ОРЛОГО	14,057.2	16,104.4	2,047.2	114.6
ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,647.1	2,047.1	400.0	124.3
ХӨРӨНГИЙН ОРЛОГО	31.4	109.4	78.0	348.4

Хүснэгтээс харахад татварын орлого 114.6 хувиар буюу 2,047.2 сая төгрөгөөр, татварын бус орлого 124.3 хувь буюу 400.0 сая төгрөгөөр, хөрөнгийн орлого 348.4 хувиар буюу 78.0 сая төгрөгөөр тус тус давж биелсэн дүнтэй байна.

2022 оны орон нутгийн төсвийн орлогын төлөвлөгөө, гүйцэтгэлийг өмнөх онуудтай харьцуулбал дараах байдалтай байна.

Хүснэгт: 3 Орлого төлөвлөгөө, гүйцэтгэлийн судалгаа сүүлийн 3 жилээр

сая төгрөгөөр



2022 оны төсвийн орлогын төлөвлөлт 2020 оноос 7,240.8 сая төгрөг, 2021 оноос 4,291.4 сая төгрөгөөр, харин орлогын гүйцэтгэл 2020 оноос 4,294.2 сая төгрөгөөр, 2021 оноос 3,071.0 сая төгрөгөөр тус тус өссөн нь цаашид аймгийн төсвийн орлого өсөх боломжтойг харуулж байна.

2022 оны төсвийн орлогын төлөвлөгөөнөөс давсан орлогын гүйцэтгэлийг нэр төрлөөр харуулбал:

**АРХАНГАЙ АЙМГИЙН ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧИЙН
2022 ОНЫ НЭГДСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН**

Хүснэгт: 3 Төлөвлөгөөнөөс давсан орлогын судалгаа

сая төгрөгөөр

№	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлтийн хувь
1	Цалин хөлс түүнтэй адилтгах орлогын татвар	5,800.0	7,318.3	1,518.3	126.2
2	Аж ахуй эрхэлсний орлогын татвар /УА-ны орлого/	700.0	785.4	85.4	112.2
3	Үл хөдлөх хөрөнгө борлуулсны орлого	126.0	258.7	132.7	205.3
4	Автомашин өөрөө явагч хэрэгслийн албан татвар	427.0	466.3	39.3	109.2
5	Газрын төлбөр	267.6	272.9	5.3	102.0
6	Газрын дуудлага худалдааны орлого	470.0	922.4	452.4	196.3
7	Хог хаягдлын үйлчилгээний хураамж	223.6	279.8	56.2	125.1
8	Байгалийн ургамал ашигласны төлбөр	1.5	1.7	0.2	-
9	Ус рашааны нөөц ашигласны төлбөр	152.0	169.2	17.2	111.3
10	Ойн нөөц ашигласны төлбөр	658.5	2,061.7	1,403.2	313.1
11	Ан амьтны нөөц ашигласны төлбөр	30.0	216.3	186.3	721.0
12	Зээлийн хүүгийн орлого	33.6	33.6	-	100.0
13	Төсөвт газрын өөрийн орлого	346.0	424.0	78.0	122.5
14	Хүү торгуулийн орлого	900.0	1,198.4	298.4	133.2
15	Нэр заагдаагүй бусад орлого	357.5	391.1	33.6	109.4
16	Орон нутгийн өмчит хөрөнгө борлуулсны орлого	31.4	109.4	78.0	348.4
	ХХОАТ-ын буцаан олголт	(800.0)	(635.0)	165.0	79.4
	Нийт	9,724.7	14,274.2	4,549.5	146.8

Төсвийн 16 нэр төрлийн орлого 0.2-1,518.3 сая төгрөгөөр буюу нийт **4,549.5** сая төгрөгөөр давж биелжээ. Үүнийг тодруулбал:

- ✓ **Цалин хөлс, түүнтэй адилтгах орлогын татвар** 1,518.3 сая төгрөгөөр давж биелсэн нь төрийн үйлчилгээний албан хаагчдын цалинг нэмэгдсэнтэй холбоотой байна.
- ✓ **Аж ахуй эрхэлсний орлогын албан татварын орлого** 85.4 сая төгрөгөөр давж биелсэн нь иргэний зарж борлуулсан ноолуур, арьс ширний урамшуулал, самрын орлогод татвар ногдуулсан, мөн үйл ажиллагааны албан татварын хяналт шалгалтын хүрээнд 38.4 сая төгрөг орсонтой холбоотой байна.
- ✓ **Үл хөдлөх хөрөнгө борлуулсны орлого** 132.7 сая төгрөгөөр давж биелсэн нь иргэд орон сууц, үл хөдлөх хөрөнгө худалдан авсантай холбоотой байна.
- ✓ **Авто болон өөрөө явагч хэрэгслийн албан татварын орлого** 39.3 сая давсан нь Татварын ерөнхий газрын албан даалгаврын хүрээнд орон нутгийн дугаартай тээврийн хэрэгслийн албан татварын өрийг барагдуулсантай холбоотой байна.
- ✓ **Газрын төлбөрийн орлогын** хувьд газрын төлбөрийн нэхэмжлэлийг ГХБХБГ-ын мэдээллийн санд үүсгэж, иргэд байгууллагууд төлбөрөө төлсөнтэй холбоотой
- ✓ **Газрын дуудлага худалдааны орлого** 452.4 сая төгрөгөөр давж биелсэн нь суманд газар зохион байгуулалтын төлөвлөгөөний дагуу дуудлага худалдаа сонгон шалгаруулалтыг зохион байгуулж, газрын байршил, зориулалт зэргээс шалтгаалан иргэд, аж ахуйн нэгж ихээр оролцсонтой холбоотой байна.

- ✓ **Хог хаягдлын хураамжийн орлого** 56.2 сая төгрөгөөр давж биелсэн нь сумд хогны хураамжийн үнэ тарифыг шинэчлэн тогтоож, аялал жуулчлалын бүс нутгуудаар тус хураамжийг цаг хугацаанд төвлөрүүлсэнтэй холбоотой байна.
- ✓ **Ус рашааны нөөц ашигласны төлбөрийн орлого** 17.2 сая төгрөгөөр давж биелсэн нь аймгийн төсөвт төвлөрөх аж нэгж байгууллагын ус ашигласны төлбөр төлөлттэй холбоотой байна.
- ✓ **Ойн нөөц ашигласны төлбөр** 1,403.2 сая төгрөгөөр давж биелсэн нь Булган, Тариат, Цэнхэр, Ихтамир, Жаргалант суманд самрыг үйлдвэр, аж ахуйн зориулалтаар ашиглах шийдвэр гарсантай холбоотой байна.
- ✓ **Ан амьтны нөөц ашигласны төлбөр** 186.3 сая төгрөгөөр давж биелсэн нь БОАЖЯ-аас ангийн зөвшөөрлийн төлөвлөгөөг аймгийн төсөв батлагдсанаас хойш баталж, Цахир, Өгийнуур, Батцэнгэл сумд ан амьтан агнах зөвшөөрлийн дагуу орлогыг төвлөрүүлсэнтэй холбоотой байна.
- ✓ **Зээлийн хүүгийн төлбөр** 33.6 сая төгрөгийг Ар Ус Ундарга ХХК-ний дамжуулан зээлтэй холбоотойгоор тус байгууллагаас төвлөрүүлсэн байна.
- ✓ **Төсөвт газрын өөрийн орлого** 78.0 сая төгрөгөөр давж биелсэн нь Цахир, Төвшрүүлэх, Эрдэнэбулган, Хангай сумд орлогын төлөвлөгөөг давуулан биелүүлсэн нөлөөлсөн байна.
- ✓ **Хүү торгуулийн орлого** 298.4 сая төгрөгөөр давж биелсэн нь тайлант онд татварын цахим систем, цахим банкны үйлчилгээг ашиглан жолооч нар торгуулийг төлөх боломжтой болж, орлого төвлөрсөнтэй холбоотой.
- ✓ **Нэр заагдаагүй бусад орлого** 33.6 сая төгрөгөөр давж биелсэн нь аймгийн Санхүүгийн аудитын алба болон ТАГ-ын 2022 онд тогтоосон актын төлбөр төлөгдсөн нь нөлөөлсөн байна.
- ✓ **Орон нутгийн өмчит хөрөнгө борлуулсны орлого** нь 78.0 сая төгрөгөөр давж биелсэн нь орон нутгийн өмчид бүртгэлтэй хөрөнгийг дуудлага худалдаагаар борлуулж, мөн түрээсээр эзэмшүүлсэнтэй холбоотой байна.

Дараах 9 нэр төрлийн орлогын төлөвлөгөө нийт **2,024.3** сая төгрөгөөр тасарсан байна. Хүснэгтээр харуулбал:

Хүснэгт: 3 Төлөвлөгөөнөөс тасарсан орлогын судалгаа

№	Үзүүлэлтийн нэр	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	сая төгрөгөөр	
				Зөрүү	Биелэлтийн хувь
1	Хөрөнгийн орлого /хадгаламжийн хүү/	1,732.8	1,219.9	(512.9)	70.4
2	Шууд бус орлого	594.0	23.5	(570.5)	4.0
3	ААН-ийн орлогын албан татвар	560.0	323.6	(236.4)	57.8
4	Үл хөдлөх хөрөнгийн албан татвар	310.0	298.5	(11.5)	96.3
5	Галт зэвсгийн албан татвар	78.0	74.2	(3.8)	95.1
6	Малын тоо толгойн албан татвар	2,348.9	1,757.9	(591.0)	74.8
7	Улсын тэмдэгийн хураамж	290.0	208.4	(81.6)	71.9
8	Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр	87.3	80.7	(6.6)	92.4
9	Хувьцааны ногдол ашиг	10.0	-	(10.0)	-
	Нийт	6,011.0	3,986.7	(2,024.3)	66.3

- Хадгаламжийн хүүгийн орлого 512.9 сая төгрөгөөр тасарсан нь банкнаас хугацаатай хадгаламжийн хүүг бууруулж, 2021 оны 02 дугаар сараас эхлэн хугацаагүй хадгаламжид хүү олгохгүй болсон зэргээс шалтгаалан иргэд хадгаламжаас мөнгөө татаж үнэт цаас, үл хөдлөх болгох сонирхолтой болсноос шалтгаалан иргэдийн хадгаламжийн хэмжээ өмнөх оноос буурсан нь нөлөөлсөн байна.
- Шууд бус орлого 570.5 сая төгрөгөөр тасарсан нь үйл ажиллагааны орлогод малчин иргэдийн малын гаралтай түүхий эд борлуулсан орлого, ноос ноолуурын урамшууллаас орсон орлого нь үйл ажиллагааны орлого руу төвлөрдөг болсон. Аймгийн Санхүү төрийн сангийн хэлтсийн тайлбараас Сангийн яамнаас өмнөх оны гүйцэтгэлд үндэслэлгүйгээр төлөвлөгөөг хэт өндөр хянасантай холбоотой гэсэн тайлбарыг ирүүлээд байна.
- Галт зэвсгийн албан татварын орлого 3.8 сая төгрөгөөр тасарсан нь цагдаагийн байгууллагын мэдээллийн баазад бүртгэлтэй галт зэвсгийн тоо татварын бүртгэл мэдээллийн нэгдсэн сангийн тоо мэдээнээс зөрүүтэй байснаас шалтгаалан тасарсан байна.
- Малын тоо толгойн албан татварын орлого 591.0 сая төгрөгөөр тасарсан нь малчдад төлсөн татвар нь юунд зарцуулагдсан талаар тодорхой мэдээлэл өгөөгүйгээс татварыг малчдад чиглэсэн үйл ажиллагаанд зарцуулахгүй байна гэсэн шалтгаанаар татвар хураалтад хүндрэл үүссэн, зарим малчид өвөлжилттэй холбоотой өөр сумдад отор нүүдэл хийж явсан зэрэг нөлөөлсөн байна.
- Улсын тэмдэгтийн хураамжийн орлого 81.6 сая төгрөгөөр тасарсан нь Иргэдийн улсын бүртгэлийн лавлагаа цахим хэлбэрт шилжсэн, нотариатын үйлчилгээ багассан, тамхи худалдаалах зөвшөөрөл бага олгогдсон зэргээс шалтгаалсан байна.
- Түгээмэл тархацтай ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн орлого 6.6 сая төгрөгөөр тасарсан нь Хайрхан болон Цахир сумдад баригдаж буй сургууль, эрүүл мэндийн төвийн барилгыг гүйцэтгэгч ААН нь элс, хайрга ашигласны төлбөрөө төлөөгүй нь нөлөөлсөн байна.
- Хувьцааны ногдол ашиг 10.0 сая төгрөгөөр тасарсан нь Орон нутгийн өмчит Ар Ус Ундарга ХХК нь 2021 онд ашиггүй ажилласнаас шалтгаалан орлого төвлөрүүлэх боломжгүй болсонтой холбоотой.

Эдгээр 9-н нэр төрлийн орлогын төлөвлөгөө 33.7 хувиар тасарсан шалтгааныг холбогдох байгууллагаас ирүүлсэн саналд үндэслэн үнэлж үзэхэд дараах шалтгаантай байна. Үүнд:

- Хадгаламжийн хүүгийн орлогын албан татвар нь татварын хэлтэс болон албадын үйл ажиллагаанаас хамаараагүй, хадгаламжийн хэмжээ буурснаас шалтгаалсан.
- Шууд бус орлого болон ААН-ийн орлого нийт 806.9 сая төгрөгөөр тасарсныг аймгийн Санхүү төрийн сангийн хэлтэс болон аймгийн Татварын хэлтсийн тайлбараас үзэхэд Сангийн яамнаас хэт өндөр төлөвлөсөнтэй холбоотой гэсэн тайлбарыг өгсөн тул эдгээр төрлийн татварын орлогын төлөвлөлтөд орон нутгийн саналыг үндэслэн хянах саналыг Сангийн Яаманд уламжлуулахаар шийдвэрлэлээ.
- Харин бусад орлогын нэр төрлийн татвараар 695.4 сая төгрөгийн орлогыг сумдын орон нутгийн төсөвт төвлөрүүлэх боломжтой байсан гэж үзэж орлогыг нэр төрлөөр жигд ханган биелүүлэхэд анхаарч ажиллах зөвлөмж хүргүүллээ.

Сумын төрийн сангийн аудитаар сумын төсвийн орлогын төлөвлөгөөг 78.2% буюу 101,2 сая төгрөгөөр тасалсан Хайрхан сум, 76.2% буюу 172.6 сая төгрөгөөр тасалсан Хотонт сумдын төрийн сангийн тайланд аудитаас Хязгаарлалттай дүгнэлтийг өглөө.

“Аж ахуйн нэгжийн орлогын албан албан татварын орлогыг аймаг, нийслэлийн төсөвт хуваарилах, үйл ажиллагааг зохицуулах, хяналт тавих журам”- дагуу аймагт хуваарилагдсан орлогын талаар:

Монгол улсын ААНОАТ-ын тухай хуулиар татварын орлого 100% улсын төсөвт төвлөрдөг байсан. Аймгийн Татварын хэлтсээс ирүүлсэн тайлбараар 2019-2022 онуудын татварын төлөвлөгөө, гүйцэтгэлээс үзэхэд тус нэр төрлийн татварыг 200.0-348.3 сая төгрөгөөр төлөвлөж, гүйцэтгэлээр 315.5-559.5 сая төгрөгийн орлого төвлөрүүлж байсан байна.

“Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай” хууль болон энэхүү хуулийг дагалдан батлагдсан “Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” хууль, Сангийн сайдын 2022 оны “Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын орлогыг аймаг, нийслэлийн төсөвт хуваарилах, үйл ажиллагааг зохицуулах, хяналт тавих журам”-ын дагуу ААНОАТ-ыг улсын төсөвт 1,000.0 сая, аймгийн төсөвт 560.0 сая төгрөгийн орлого төвлөрүүлэхээр Сангийн яамнаас хянажээ.

Архангай аймагт үйл ажиллагаа явуулж буй 600 гаруй аж ахуй нэгжийн бүртгэлд суурилан ААНОАТ-ын төлөвлөгөөг хийж байгаа бөгөөд эдгээрийн 63.3% нь бичил аж ахуй эрхлэгчид, 35 % нь жижиг, 1.3 хувь нь дунд аж ахуй эрхлэгчид байна. 2022 онд аж ахуйн нэгжийн орлогын албан татвараар улсын төсөвт 764.2 сая төгрөгийг төсөвт төвлөрүүлсний 42.3% буюу 323.6 сая төгрөгийг аймгийн төсөвт 2022 оны 02 дугаар сарын 17-оос 12 дугаар сарын 30-ны хооронд 12 удаагийн гүйлгээгээр 100010000203 тоот аж нэгжийн орлогын албан татварын дансанд төвлөрүүлсэн байна. Тус орлогыг аймгийн төсвийн орлогын 100010000910 тоот дансанд татан төвлөрүүлж орон нутгийн суурь зарлагын эх үүсвэрт хуваарилсан байна.

БҮЛЭГ 2. ТӨСВИЙН ЗАРЛАГЫН ГҮЙЦЭТГЭЛ 81.7 ХУВЬТАЙ БАЙНА.

2.1. ТӨСВИЙН ЗАРЛАГЫН ТӨЛӨВЛӨЛТ



Төсвийн ерөнхийлөн захирагч нарын 2022 оны төсвийн төсөл бэлтгэх удирдамжид заасны дагуу Архангай аймгийн орон нутгийн 2022 оны төсвийн суурь зарлагын төслийг **35,277.4** сая төгрөгөөр боловсруулж, Төсвийн тухай хуулийн 8.4.3 дахь заалтын дагуу Сангийн яаманд хүргүүлжээ. Сангийн яам саналыг **2,255.1** сая төгрөгөөр буюу **6.4** хувиар бууруулан **33,022.3** сая төгрөгөөр хянасан байна.

Орон нутгаас хүргүүлсэн суурь зарлагын төслийг өмнөх оны төлөвлөгөө, Сангийн яамны хянаж ирүүлсэн болон Аймгийн ИТХ-аар баталсан дүнтэй харьцуулж хүснэгтээр харуулбал:

**АРХАНГАЙ АЙМГИЙН ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧИЙН
2022 ОНЫ НЭГДСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН**

Хүснэгт: 6 Орон нутгийн суурь зарлага төлөвлөлтийн судалгаа

сая төгрөгөөр

Үзүүлэлт	2021 оны Төлөвлөгөө	2022 оны санал /суурь /	Сангийн Яам хянаж УИХ баталсан / суурь /	Анх баталсан	Тодотгон баталсан	Зөрүү +-	Хувь
Орон нутгийн төсвийн суурь зарлага	21,498.4	35,277.4	33,022.3	33,022.3	28,250.9	-4,771.4	85.6

Хүснэгтээс харахад:

2022 оны орон нутгийн төсвийн зарлагыг нийт дүнгээр **35,277.4** сая төгрөгөөр төлөвлөсөн нь 2021 оны төлөвлөгөөнөөс **13,779.0** сая төгрөгөөр буюу **64.0** хувиар нэмэгдсэн байна.

Энэ нь Сангийн Яамнаас 2022 оны төсвийн жилийг төсвийн шинэчлэлийн жил болгосонтой холбогдуулан тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагын тогтмол зардлыг орон нутагт шилжүүлэх, орон нутгийн засаг захиргаа, нутгийн өөрөө удирдах ёсны байгууллага, сумдын ерөнхий боловсролын сургууль, дотуур байр, хүүхдийн цэцэрлэг, эрүүл мэндийн төв, соёлын төв, номын сан, музей, театр, биеийн тамир спорт, мэргэжлийн боловсрол зэрэг байгууллагуудын цэвэрлэгээ, харуул хамгаалалт, автомашин, цахилгаан, халаалтын үйлчилгээ болон хоол үйлдвэрлэл зэргийг хувийн хэвшлээс гэрээний үндсэн дээр худалдан авахаар тооцож өмнөх онтой харьцуулахад томоохон өөрчлөлтийг оруулан хянажээ.



Төсвийн тодотголд дээр дурдсан өөрчлөлтүүд хийгдэж орон нутаг дахь ерөнхий боловсролын сургууль, хүүхдийн цэцэрлэг, мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв, театр, музей, номын сан, сумын соёлын төв зэрэг байгууллагын байрны үйлчилгээний чиг үүргийг хэрэгжүүлдэг төрийн үйлчилгээний ТҮ1-ТҮ3 зэрэглэлийн албан хаагчдын цалинг ялгаатай эх үүсвэрээс олгодог болсноор салбарын хэмжээнд ажиллагсдын ажлын гүйцэтгэл, үр дүнг үнэлэх, түүнтэй уялдсан цалин хөлсний бодлого хэрэгжүүлэхэд хүндрэл үүссэн тул үйлчилгээний албан хаагчдыг үндсэн байгууллагадаа харьяалагддаг байх өөрчлөлтийг тусган УИХ-аас 2022 оны 4 дүгээр сарын 29-ний өдөр баталсан “2022 оны төсөвт өөрчлөлт оруулах тухай” хуулиар орон нутгийн суурь зарлагыг анх хянасан дүнгээс **4,771.4** сая төгрөгөөр бууруулж, **28,250.9** сая төгрөгөөр Сангийн яамнаас хянасан байна.

Аймгийн ИТХ-ын 2021 оны 12 сарын 02-ны өдрийн “Аймгийн 2022 оны төсөв батлах тухай” 14 дүгээр тогтоолоор аймгийн төсвийн орлого, зарлагын тэнцлийг **44,918.5** сая төгрөгөөр баталсан ба аймгийн 2022 оны төсөвт 1 удаа тодотгол хийгдэж, Аймгийн ИТХ-ын 2022 оны 06 сарын 06-ны өдрийн “Аймгийн 2022 оны тодотгон төсөв батлах тухай” 11 дүгээр тогтоолоор аймгийн төсвийн орлого, зарлагын тэнцлийг **41,449.3** сая төгрөгөөр буюу анх баталсан төсвөөс **3,469.2** сая төгрөгөөр бууруулан баталжээ.

Аймгийн 2022 оны төсвийн тодотголд ТАГ-аас хийсэн шалгалтаар өгсөн зөвлөмжийн талаар:

Тайлангийн жилийн 11 дүгээр сард УИХ-ын гишүүнээс гомдол уламжлах тухай мэдээллийн ирүүлсний дагуу төсвийн тодотгол болон бусад холбогдох асуудлыг ТАГ нь шалган хариуг хүргүүлж ажилласан. Энэхүү шалгалтын дүнд

дараах зөрчил илэрч аудитын шийдвэрийг хүргүүлэн биелэлтийг хангуулан төсвийн **1,317.2** сая төгрөг хэмнэлтийг бий болгосон байна. Үүнд:

- 2022 оны 6 дугаар сард аймгийн төсөвт оруулсан тодотголыг авч үзэхэд : Сангийн яамнаас нийт зардлыг **4,771.4** сая төгрөгөөр хасаж, аймгийн ЗДТГ-ын ТҮ1-ТҮ3 хүртэлх цалинтай албан хаагчдын цалин, НДШ-ийг 162.0 сая төгрөгөөр нэмж тодотгохоор хянасан байна. Харин аймгийн ИТХ-ын 2022 оны 11 дүгээр тогтоолоор нийт зардлын дүнг **3,469.2** сая төгрөгөөр бууруулсан буюу Сангийн яамны хянасан дүнгээс **1,302.2** сая төгрөгөөр зардлын дүнг нэмэгдүүлж баталсан байв.
- Төсвийн тодотголоор Сангийн яамнаас хянасан суурь орлого зарлагын дүнг гол үндэслэл болгон төсвийн тэнцлийг хангах үүднээс аймгийн төвийн Эрдэнэбулган сумын 2022 оны төсвийн суурь орлого, зарлагын зөрүү **1,317.2** сая төгрөгийг 100% аймгийн төсөвт татан төвлөрүүлэхээр баталжээ. *Энэ нь Төсвийн тухай хуулийн 56 дугаар зүйлийн 56.2.1-д “доод шатны төсвийн үндсэн тэнцлийн ашиг нь суурь зарлагаас бага болон тэнцүү тохиолдолд үндсэн тэнцлийн ашгийн 70 хувийг ... тухайн шатны төсөвт үлдээж, үлдэх хэсгийг дээд шатны төсөвт төвлөрүүлнэ” гэж заасныг зөрчсөн байна.*
- Төсвийн тодотголоор нэр бүхий байгууллагуудын тогтмол зардлын дүнг анх баталснаас 783.0 сая төгрөг, ашиглалтын зардлын дүнг 64.0 сая төгрөгөөр үндэслэлгүйгээр нэмэгдүүлсэн. Тухайлбал: Өлзийт сумын төсөвт байгууллагуудын халаалтын өр төлбөрийн үлдэгдлийг барагдуулах зорилгоор 414.7 сая төгрөг , Хайрхан суманд шинээр ашиглалтад орох сургуулийн барилгын халаалтын зардал 237.5 сая төгрөгийг хуваарилсан байна. Түүнчлэн 472.3 сая төгрөгийг төсөв захирагчдад хуваарилахгүйгээр нөөц байдлаар тооцож “Төрийн өмчит байгууллагуудын тогтмол зардал” гэсэн нэрээр баталсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.6.4-д *“төсөв батлах эрх бүхий байгууллага нь төсвийг шатлал бүрээр, түүнд харьяалагдах төсвийн ерөнхийлөн захирагч, тэдгээрийн хэрэгжүүлэх хөтөлбөр, хүрэх үр дүн, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, тусгай сан, орлого, санхүүжүүлэх эх үүсвэр бүрээр нь батлах”* гэж заасантай нийцэхгүй байна.

Аймгийн ИТХ-ын 2022 оны 11 дүгээр тогтоолоор урьд оны үлдэгдлээс санхүүжүүлэхээр тооцож *тодорхой нэр төрлийн урсгал зардлуудын дүнг нэмэгдүүлсэн* нь төсөвт тодотгол хийх гол шалтгаанаас гажсан, “санхүүгийн сахилга батыг мөрдүүлж, ил тод байдлыг хангах, үр ашгийг нэмэгдүүлэх, үрэлгэн байдлыг хязгаарлах...” Төрийн хэмнэлтийн тухай хуулийн зорилготой нийцээгүй холбогдох хуулийн хэрэгжилтийг хангаагүй байна гэж аудитаас үзсэн.

Иймд аудитаас Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг хангаж, төсвийн тодотголоор нэмэгдүүлж баталсан аймгийн *Засаг даргын нөөц хөрөнгө, Засаг даргын ерөнхий дансыг* 11 дүгээр сарын 10-ны өдрөөр тасалбар болгон царцааж төсвийг хэмнэх, цаашид зардлыг нэмэгдүүлэх явдлыг таслан зогсоох арга хэмжээ авч, төсөв захирагчид хуваарилаагүй 472.3 сая төгрөг, Хайрхан сумын ашиглалтад ороогүй ЕБС-ийн барилгын ашиглалтын зардалд хуваарилсан 237.5 сая төгрөг нийт 709.8 сая төгрөгийн төсвийг хэмнэх зөвлөмжийг аймгийн Засаг даргад хүргүүлж биелэлтийг хангуулсан.

2.2 ТӨСВИЙН ЗАРЛАГЫН ГҮЙЦЭТГЭЛ



Аймгийн ТЕЗ-ийн 2022 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлд орон нутгийн төсвийн шууд захирагчийн 50, боловсролын салбарын 68, эрүүл мэндийн 22, соёлын салбарын 23, биеийн тамир спортын 1, мэргэжлийн боловсролын 1 /байр ашиглалттай холбоотой тогтмол зардал/, 41 тусгай сан, аймгийн засаг дарга дансны гүйцэтгэл нэгтгэгдлээ.

Аймгийн төсвийн 2022 оны нийт зарлага фискал программд /төсвийн гүйцэтгэлийн тайлангаар/ нийт **51,675.3** сая төгрөг төлөвлөгдөж, гүйцэтгэлээр **42,228.6** сая төгрөгийг зарцуулан, төсвийн гүйцэтгэл **81.7** хувьтай тайлагнагджээ.

Аймгийн ТЕЗ-ийн 2022 оны төсвийн гүйцэтгэлийн тайлангаарх нийт зарлагын төлөвлөгөөний дүн аймгийн ИТХ-аар баталсан дүнгээс **10,226.0** сая төгрөгөөр илүү тайлагнагдсан нь сумын ИТХ-ын хурал бүрэн эрхийн хүрээнд хоршоо хөгжүүлэх сангийн төлөвлөгөөг **4,041.4** сая төгрөгөөр, сумын ОНХС-ийн урьд оны үлдэгдэл **2,816.2** сая төгрөгөөр, сумдын урьд оны үлдэгдэл **3,064.8** сая төгрөгөөр, ерөнхий боловсролын сургуулиудын халаалтын өөрийн орлого **34.3** сая төгрөг, орон нутгийн төсвийн орлогыг **393.5** сая төгрөгөөр тус тус нэмэгдүүлэн баталсан, харин Эрдэнэбулган сум хог хаягдлын хураамжийн **124.2** сая төгрөгийн зардлыг бууруулан баталсантай холбоотой байна.

Нийт **51,675.3** сая төгрөгийн зарлагын **30,726.0** сая төгрөг буюу 59.5 хувийг орон нутгийн төсвөөс, **6,816.9** сая төгрөг буюу 13.2 хувийг ОНХС-аас, **10,093.6** сая төгрөг буюу 19.5 хувийг урьд оны үлдэгдлээс, **4,039.8** сая төгрөг буюу 7.8 хувийг төсөвт байгууллагын үйл ажиллагааны орлогоос санхүүжүүлэхээр хуваарилсан байна.

2022 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлийг зардлын нэр төрлөөр харуулбал дараах байдалтай байна.

Хүснэгт: 7 Орон нутгийн 2022 оны төсвийн төлөвлөгөө, гүйцэтгэлийн судалгаа

сая төгрөгөөр

ҮЗҮҮЛЭЛТ	2021 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл		2022 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл				Өмнөх оны төлөвлөгөөн өөс	Өмнөх оны гүйцэтгэлээс
	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь		
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	90,502.1	81,726.2	51,675.3	42,228.6	9,446.7	81.7	38,826.8	39,497.6
А. УРСГАЛ ЗАРДАЛ	77,557.0	74,620.6	32,027.8	29,120.8	2,907.0	90.9	45,529.2	45,499.8
БАРАА ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	75,836.3	73,003.2	30,101.8	27,271.2	2,830.6	90.6	45,734.5	45,732.0
ТАТААС	108.9	89.0	108.0	89.2	18.8	82.6	0.9	(0.2)
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,611.8	1,528.4	1,818.0	1,760.4	57.6	96.8	(206.2)	(232.0)
Б. ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	9,894.1	5,914.0	15,619.7	10,522.7	5,097.0	67.4	(5,725.6)	(4,608.7)
В. ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	3,051.0	1,191.6	4,027.8	2,585.1	1,442.7	64.2	(976.8)	(1,393.5)

**АРХАНГАЙ АЙМГИЙН ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧИЙН
2022 ОНЫ НЭГДСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН**

Хүснэгтээс харахад тайлант оны төсвийн гүйцэтгэлийн төлөвлөгөө өмнөх оны төлөвлөгөөнөөс 38,826.8 сая төгрөгөөр, гүйцэтгэл 39,497.6 сая төгрөгөөр буюу 51.7 хувиар буурсан байна.

Энэ нь төсвийн шинэчлэлийн хүрээнд боловсрол эрүүл мэндийн байгууллагыг гүйцэтгэл, үр дүнд суурилсан тогтолцоонд шилжүүлэн, улсын төсвийн байгууллага болж, орон нутгаас зөвхөн байр ашиглалт, урсгал зардалтай холбоотой тогтмол зардлын санхүүжилтийг олгодог болсонтой холбоотой байна.

Төсвийн гүйцэтгэлийг аймаг, сумдаар харуулбал:

Хүснэгт:8 Аймаг сумдын 2022 оны төсвийн төлөвлөгөө, гүйцэтгэлийн судалгаа *сая төгрөгөөр*

Нэр	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Гүйцэтгэлийг задалбал:		
				Эргэж төлөгдөх зээл	Хөрөнгийн зардал	Урсгал зардал
Сумын дүн	35,871.6	30,214.3	5,657.3	2,585.1	4,350.4	23,278.8
Аймгийн дүн	15,803.7	12,014.3	3,789.4	-	6,172.3	5,842.0
	51,675.3	42,228.6	9,446.7	2,585.1	10,522.7	29,120.8

Төсвийн гүйцэтгэлийн тайлангаар нийт **9,446.7** сая төгрөгийн хэмнэлтэд дараах шалтгаанууд нөлөөлсөн байна.Үүнд:

- Төрийн аудитын газраас төсвийн тодотголыг шалгаж хүргүүлсэн зөвлөмжийн дагуу аймгийн засаг даргын нөөц хөрөнгийн **599.1** сая, төсөв захирагчид хуваарилаагүй тогтмол зардал **472.3** сая, гамшгаас хамгаалах зардлаас **150.0** сая, Хайрхан сумын санхүүгийн дэмжлэгээс **150.0** сая, нийт **1371.4** сая төгрөгийн санхүүжилтийг царцаасантай холбоотой хэмнэгдсэн.
- Аймгийн ЗДТГ-ын **130.4** сая, аймгийн ИТХ-ын **20.5** сая, Биеийн тамир спортын газарт **101.1** сая, соёл урлагийн газарт **32.8** сая, Халамжийн санд **27.6** сая нийт 312.4 сая төгрөгийн санхүүжилтийг дутуу олгож хэмнэсэн,
- Сумын удирдлагын байгууллагуудын хөрөнгийн зардлын зарцуулагдаагүй үлдэгдэл **187.8** сая төгрөг,
- Орон нутгийн төсвийн байгууллагуудын урсгал зардлын хэмнэлтээс төвлөрүүлсэн нийт **915.1** сая төгрөг,
- Аймаг сумдын ОНХС-д малын хөлийн татвараар орох орлого бүрэн төвлөрөөгүй, бусад шалтгаанаар **4,301.4** сая төгрөгийн төвлөгдсөн арга хэмжээ хэрэгжээгүй
- Сумын хоршоо хөгжүүлэх сангийн зээлийн эргэн төлөлтөөс шалтгаалан **1,442.7** сая төгрөгийн зээл олгогдоогүй
- Мал хамгаалах сангийн төлөвлөсөн зардлын зөрүү **24.8** сая төгрөг
- Шинээр баригдаж буй театрын барилга ашиглалтад ороогүй тул тогтмол зардлын **455.8** сая төгрөгийн санхүүжилтийг олгоогүй зэргээс шалтгаалан төсвийн зардлууд хэмнэгдсэн байна.

Аймгийн ТЕЗ-ийн хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээний талаар:

Аймгийн ИТХ-ын 2022 оны 06 дугаар сарын 06-ны өдрийн “Аймгийн 2022 оны тодотгосон төсөв батлах тухай” 11 дүгээр тогтоолоор “Аймгийн ТЕЗ-ийн хэрэгжүүлэх хөтөлбөр, хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлтийг аймгийн 2022 оны хөгжлийн төлөвлөгөөнд үндэслэн нийт ТЕЗ, түүний хэрэгжүүлэх 10 салбар чиглэлийн дагуу баталжээ.

Аймгийн хөгжлийн 2022 оны жилийн төлөвлөгөөний **175** арга хэмжээний хэрэгжилтэд 2022 оны жилийн эцсийн байдлаар хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, арга хэмжээний зорилтот түвшинд бүрэн хүрсэн буюу 100 хувьтай арга хэмжээ **79**, арга хэмжээний хүрэх түвшинд бүрэн хүрээгүй боловч зохион байгуулалтын арга хэмжээ бүрэн авагдсан, холбогдох байгууллагын шийдвэр гарсан, гол үр дүн нь гарч эхэлж байгаа буюу 90.0 хувьтай арга хэмжээ **40**, тавьсан зорилт, арга хэмжээнд хүрэх зорилгоор өөрсдөөс хамаарах шийдвэрийг гаргасан, санхүүгийн асуудал шийдвэрлэгдсэн, дээд шатны байгууллагад өргөн барьсан буюу гүйцэтгэл нь тодорхой хэмжээгээр гарч эхэлж байгаа буюу 70.0 хувьтай арга хэмжээ **25**, бэлтгэл болон боловсруулалтын шатны ажил бүрэн хийгдсэн, ажил тодорхой хэмжээнд эхэлсэн буюу 50.0 хувьтай арга хэмжээ **7**, бэлтгэл ажил хийгдэж дуусаад боловсруулалтын шатанд байгаа буюу 30 хувьтай арга хэмжээ **15**, хэрэгжүүлэх талаар ямар нэгэн ажил зохион байгуулаагүй “0” хувьтай арга хэмжээ **9**, нийт арга хэмжээний хэрэгжилтийн дундаж **82.6** хувьтай үнэлжээ.

Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.5-д заасны дагуу аймгийн ТЕЗ-ийн хөтөлбөрөөр бэлтгэсэн тайланг ирүүлсэн бөгөөд дараах байдалтай байна.

Хүснэгт:9 Аймгийн ТЕЗ-ийн 2022 оны хөтөлбөрөөр бэлтгэсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

№	ҮЗҮҮЛЭЛТ	ТӨЛӨВЛӨГӨӨ	ГҮЙЦЭТГЭЛ	ЗӨРҮҮ	ХУВЬ
1	70105 ОН-ын өөрөө удирд ёсны байгууллага	2,915.2	2,692.2	223.0	92.4
2	70106 ОН-ын гүйцэтгэх засаглалын удирдлага	17,867.5	15,499.9	2,367.6	86.7
3	70417 Мэргэжлийн хяналт	140.4	139.7	0.7	99.5
4	70426 Төрийн өмчийн эрхийг хэрэгжүүл	161.2	159.2	1.9	98.8
5	70501 ОН-ын төсөвт олгох орлогын шилжүүлэг	12,247.6	7,946.3	4,301.4	64.9
7	70801 Мал аж ахуйг хөгжүүлэх	1,029.6	999.0	30.6	97.0
8	71403 Ойжуулалт	174.6	170.8	3.8	97.8
9	71411 Хүрээлэн буй орчны бодлого, удирдлага	1,199.9	1,181.9	18.0	98.5
10	71502 Хот байгуулалт, тохижилт	543.5	543.3	0.2	100.0
11	71602 Эмнэлгийн тусламж үйлчилгээ	607.9	566.2	41.7	93.1
12	71701 Биеийн тамир спорт	545.2	444.1	101.2	81.4
13	71702 Соёл урлаг	1,502.6	993.4	509.2	66.1
14	71801 Сургуулийн өмнөх боловсрол	1,986.0	1,899.2	86.8	95.6
15	71802 Ерөнхий боловсрол	6,310.1	6,001.9	308.2	95.1
16	71804 Мэргэжлийн боловсрол	195.3	195.3	0.0	100.0
17	71902 Нийгмийн халамж	122.4	91.2	31.2	74.5
18	72101 Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих	4,041.4	2,620.2	1,421.2	64.8
19	72208 Ахмад настны хөгжил хамгаалал	84.7	84.7	-	100.0
	нийт	51,675.3	42,228.6	9,446.7	81.7

Худалдан авсан, бараа ажил үйлчилгээний гүйцэтгэлийн талаар:

Төсвийн ерөнхийлөн захирагч нь төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн болох худалдан авсан бараа ажил, үйлчилгээний гүйцэтгэлийг Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.5.3-д заасны дагуу тайлагнасан байна.

Үүнд: Хүснэгт 8: худалдан авсан бараа ажил, үйлчилгээний гүйцэтгэл /мянган.төгрөг/

№	Худалдан авсан бараа, ажил, үйлчилгээний эх үүсвэр	Худалдан авсан бараа, ажил үйлчилгээний тоо	Төсөвт өртөг	Гэрээ байгуулсан
1	Аймгийн ОНХС	16	4,072.8	4,028.4
2	Их засвар -ОНТХО	1	1,230.0	1,201.7
3	Авто замын сан	6	1,156.0	1,111.4
	Нийт	23	6,458.8	6,341.5

Аймгийн ТЕЗ-ийн орон тооны талаар:



Аймгийн ТЕЗ нь 2022 онд нийт батлагдсан орон тооноос 14 орон тоогоор дутуу ажилласан байгааг хүснэгтээр задлан харуулбал:

Хүснэгт: 10 Аймаг сумдын байгууллагуудын 2022 оны орон тооны судалгаа

№	Байгууллагын нэр	Орон тоо		
		төлөвлөгөө	гүйцэтгэл	зөрүү
1	Архангай шууд	193	193	0
2	Их Тамир	69	68	1
3	Чулуут	65	65	0
4	Хангай	56	56	0
5	Тариат	65	66	-1
6	Өндөр улаан	80	79	1
7	Эрдэнэмандал	85	85	0
8	Жаргалант	62	62	0
9	Цэцэрлэг	65	65	0
10	Хайрхан	63	63	0
11	Батцэнгэл	63	66	-3
12	Өлзийт	52	52	0
13	Өгийнуур	54	53	1
14	Хашаат	58	55	3
15	Хотонт	78	74	4
16	Цэнхэр	69	65	4
17	Төвшрүүлэх	60	60	0
18	Булган	52	52	0
19	Эрдэнэбулган	316	312	4
20	Цахир	49	49	0
		1,654	1,640	14

Тариат сум 1, Батцэнгэл сум- 3 батлагдсан орон тооноос хэтрүүлэн ажилласан бол Хотонт, Цэнхэр, Эрдэнэбулган сумд -4, Ихтамир,Өгийнуур, Өндөр-Улаан сумд-1, Хашаат-3 орон тоогоор дутуу ажилласан байна.

Орон нутгийн хөгжлийн сангийн гүйцэтгэл:



Архангай аймгийн ИТХ-ын 2022 оны 6 дугаар сарын 06-ны өдрийн “Аймгийн 2022 оны тодотгосон төсөв батлах тухай” 11 дүгээр тогтоолоор аймгийн орон нутгийн хөгжлийн санд **3,704.9** сая, сумдын орон нутгийн хөгжлийн санд **3,377.5** сая, малын тоо толгойн албан татварын орлогоос **2,327.8** сая, нийт **9,410.3** сая төгрөгийг зарцуулахаар баталсан байна.

Харин сумдын ОНХС-ийн нийт зарлагыг **8,542.7** сая төгрөгөөр төлөвлөж, **5,640.8** сая төгрөгийг зарцуулж, гүйцэтгэл **66.0** хувь, аймгийн орон нутгийн хөгжлийн сан **3,704.9** сая төгрөг төлөвлөж **2,305.5** сая төгрөгийг зарцуулж, гүйцэтгэл **62.2** хувьтай байна. Малын тоо толгойн албан татварын гүйцэтгэл хангалтгүйгээс гүйцэтгэл бага хувьтай байна.



Аймгийн ОНХС-ийн 2022 оны гүйцэтгэлийг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт: 11 Аймгийн ОНХС-ийн 2022 онд хийгдсэн ажлууд

№	Төсөл арга хэмжээ	Төсөвт өртөг	2022 онд санхүүжүүлэх дүн	Олгосон санхүүжилт	Тайлбар
1	Багийн төвийн барилга /Хотонт сум Хөөвөр баг	100.0	100.0	94.7	
2	Багийн төвийн барилга /Батцэнгэл сумын Баян уул баг/	100.0	100.0	92.7	
3	Багийн төвийн барилга /Хайхан сумын Хайрхан баг/	100.0	100.0	94.6	
4	Өндөр-Улаан суманд ковш худалдан авах	100.0	100.0	100.0	
5	Өгийнуур сумын Эрүүл мэндийн төвийн ариун цэврийн байгууламж	50.0	50.0	-	Гүйлгээ хаасны дараа баримт ирүүлж, барьцаа хөрөнгийн дансанд авсан
6	Жаргалант сумын Эрүүл мэндийн төвийн ариун цэврийн байгууламж	50.0	50.0	47.8	
7	Эрдэнэбулган сумын 6 багийн хогийн цэг цэгцлэх	20.0	20.0	20.0	
8	Эрдэнэбулган сумын 7 багт ундны усны худаг байгуулах	30.0	30.0	27.4	
9	Эрдэнэбулган сумын нэгдсэн камержуулалтын системд холбох	450.0	450.0	415.3	
10	Цахим Архангай хөтөлбөр	1,500.0	1,272.2	-	Гүйцэтгэл хангалтгүй
11	Эрдэнэмандал сумын шинэ хуучин эмнэлгийг холбох хүзүүвчний барилга	100.0	100.0	93.6	
12	Цагаан идээний хүргүүр / Ихтамир сум/	100.0	100.0	96.9	
13	Чулуут сумын хог, хаягдлын менежмент	120.0	120.0	116.9	

**АРХАНГАЙ АЙМГИЙН ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧИЙН
2022 ОНЫ НЭГДСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН**

14	Тариат сумын Соёлын төвийн засвар	100.0	100.0	77.3	
15	Цэцэрлэг сумын ахуйн үйлчилгээний барилгын засвар	50.0	50.0	48.7	
16	Төвшрүүлэх сумын баяр наадмын талбайн засвар	35.0	35.0	35.0	
17	Хотонт сумын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө	80.0	80.0	-	Хэрэгжээгүй
18	Эрдэнэбулган сумын 2 дугаар багт гэрэлт цамхаг	30.0	30.0	28.5	
19	13 дугаар цэцэрлэгийн хүүхдийн тоглоомын талбай	35.0	35.0	14.4	
20	Замын барилгын зураг төсөв, ТЭЗҮ боловсруулах	547.8	547.8	362.4	
21	Ихтамир сумын Хүүхдийн цэцэрлэгийн засвар	60.0	60.0	54.3	
22	Баяр наадмын зардал	15.0	15.0	15.0	
23	Аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө боловсруулах /12-16 жил/	650.0	89.9	89.9	
24	Малын гаралтай бүтээгдэхүүнд анхан шатны боловсруулалт хийх үйлдвэр, хүнсний ногооны зоорь /Эрдэнэбулган сум 6 дугаар баг/	150.0	70.0	64.0	
	Барьцаа хөрөнгөнд шилжүүлсэн			316.1	
	Нийт дүн	4,572.8	3,704.9	2,305.5	

Аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр 24 төсөл арга хэмжээ хэрэгжүүлэхээр батлагдсанаас 1,402.2 сая төгрөгийн 3 ТАХ хэрэгжээгүй, нийт төсвийн 30.8% буюу 1,410.0 сая төгрөгийн 18 төсөл арга хэмжээг аймгийн 14-н суманд жижиглэн хуваарилснаас үзэхэд ОНХС-ийн хөрөнгийг Төсвийн тухай хуулийн 63² дугаар зүйл, “ОНХС-ийн үйл ажиллагааны журам”-ын 6,7³-р зүйлд заасны дагуу олон нийтийн санал асуулгаар хэлэлцэж эрэмбэлэгдсэн, иргэдийн хэрэгцээ шаардлага, хүртэх үр өгөөж, үр дүнг нь бодиттой тооцсон, хуулиар тогтоосон чиг үүрэгт нийцэхүйц төсөл арга хэмжээнд төлөвлөж, батлах албан шаардлагыг ОНХС-ийн хөрөнгийн зарцуулалтын аудитаар хүргүүлж ажилласан.

Эрдэнэмандал сумын Засаг даргын 2022 оны тайланд ОНХС-аас нийт 22.9 сая төгрөгийг иргэдийн саналд үндэслээгүй, урсгал зардалд зарцуулсан зөрчил илэрсэнд аудитаас Хязгаарлалттай санал дүгнэлтийг хүргүүлсэн.

Авто замын сангийн гүйцэтгэл:



Орон нутгийн авто замын сангийн хөрөнгөөр 10 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр **986.8** сая төгрөг баталснаас, гүйцэтгэлээр 5 төсөл, арга хэмжээнд **571.9** сая төгрөгийг олгож, бүрэн хийж гүйцэтгээгүй 4 төсөл арга хэмжээний **390.0** сая төгрөгийг аймгийн хөрөнгө оруулалтын барьцаа хөрөнгийн дансанд төвлөрүүлсэн байна.

² Орон нутгийн төсөвт иргэд, олон нийтийн оролцоог хангах

³ОНХС-ийн үйл ажиллагааг төлөвлөх

**АРХАНГАЙ АЙМГИЙН ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧИЙН
2022 ОНЫ НЭГДСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН**

№	Төсөл арга хэмжээ	Хэрэгжих хугацаа		Төсөвт өртөг	2022 онд санхүүжүүлэх дүн	Олгосон санхүүжилт	Тайлбар
		Эхлэх	Дуусах				
1	Авто зогсоол байгуулах	2022	2022	75.8	100.0	74.2	
2	Эрдэнэбулган сум доторх хатуу болон хайрган хучилттай авто замын засвар арчилалт, тэмдэг тэмдэглэгээ	2022	2022	236.0	236.0	233.4	
3	Булган сумын Тусгалт багийн Хавтгайн голын модон гүүр барих	2022	2022	120.0	120.0	-	Тендер орой зарлагдаж, газар хөлдсөн тул гэрээг сунгасан тул барьцаа хөрөнгийн дансанд дансанд авсан
4	Эрдэнэбулган сумын 6 дугаар багийн Элстэйн голын дээр модон гүүр барих	2022	2022	50.0	50.0	49.3	
5	Цахир сумын төв доторх бетон хучилттай авто зам барих	2022	2023	700.0	200.0	-	Он дамжин хэрэгжиж буй ажил, барьцаа хөрөнгийн дансанд авсан
6	Хангай сумын давааны авто замын засвар	2022	2022	20.0	20.0	-	Гэрээ оройтож байгуулагдан, тул барьцаа хөрөнгийн дансанд авсан
7	Эрдэнэбулган сумын 2 дугаар багийн Арслан цохио чиглэлийн авто зам	2022	2022	50.0	50.0	-	Материалын үнийн зөрүү гарч төсөвт өртөгт өөрчлөлт орж гэрээг сунгасан
8	Цагаан давааны ганц модны рашааны орчимд ослын зогсолтын гарц, тайлбай байгуулах	2022	2022	45.0	45.0		Тендер амжилтгүй болсон
9	Цэнхэр сумын хатуу хучилттай авто замын ажилд үзүүлэх дэмжлэг	2022	2022	200.0	200.0	200.0	
10	Жаргалант сумын модон гүүр засварлах	2022	2022	15.0	15.0	15.0	
	Барьцаа хөрөнгийн дансанд шилжүүлсэн					390.0	
				1,511.8	1,036.0	961.9	

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын гүйцэтгэл:



Аймгийн орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын 2022 оны төлөвлөгөөнд их засварын 11 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлж **1,102.8** сая төгрөг зарцуулахаар баталснаас, гүйцэтгэлээр 11 төсөл, арга хэмжээнд **1,043.4** сая төгрөгийн санхүүжилтийг гэрээнд заасны дагуу олгож, **39.5** сая төгрөгийг чанарын баталгаа болгож хөрөнгө оруулалтын барьцаа хөрөнгийн дансанд шилжүүлсэн байна.

ОНТХО-аар хэрэгжүүлсэн их засварын ажлын **1,043.5** сая төгрөгийн гүйцэтгэлтэй 11 төсөл арга хэмжээ нь тайлант жилд бүрэн хэрэгжсэн бөгөөд зураг төсөв, ажлын

даалгавартай тул захиалагч байгууллагыг төлөөлж аймгийн ГХБХБГ-ын хяналтын инженер хяналтыг хэрэгжүүлж ажилласан байна. Төсөл арга хэмжээний гүйцэтгэл, ашиглалт хэвийн байна.

Халамжийн сангийн гүйцэтгэл:



Аймгийн 2022 оны төсвийг батлахдаа Халамжийн сангийн зарлагыг аймгийн ИТХ-аар **122.4** сая төгрөгөөр төлөвлөснөөс гүйцэтгэлээр **94.8** сая төгрөгийн санхүүжилт олгосон байна. Төлөвлөгөөгөөр халамжийн сангийн орон нутгийн оролцоонд түшиглэсэн үйлчилгээнд 30.0 сая, онцгой тохиолдлын мөнгөн тусламжид 92.4 сая, нийт 122.4 сая төгрөгөөр баталснаас гүйцэтгэлээр орон нутгийн оролцоонд түшиглэсэн үйлчилгээнд 27.6 сая төгрөгийг 104 иргэнд, онцгой тохиолдлын мөнгөн тусламжид 63.6 сая төгрөгийг 53 иргэнд нийт **91.2** сая төгрөгийг зарцуулж, 3.6 сая төгрөгийн орон нутгийн төсвийн дансанд буцаан төвлөрүүлжээ.

Мал хамгаалах сангийн гүйцэтгэл:



Аймгийн Мал хамгаалах сангийн зарлагын төлөвлөгөөг аймгийн ИТХ-аар 40.0 сая төгрөгөөр баталснаас, гүйцэтгэлээр 2 ажилтны цалин, шимтгэлийн зардалд 15.2 сая төгрөгийг зарцуулсан байна. Тус сан нь үндсэн үйл ажиллагааны хүрээнд 57.3 сая төгрөгийн орлого бүрдүүлж, 100.9 сая төгрөгийн өвс тэжээлийг худалдан борлуулж, зарцуулжээ.

Гамшгаас хамгаалах зардлын гүйцэтгэл:



Аймгийн ТЕЗ-аас гамшгаас хамгаалах арга хэмжээг хэрэгжүүлэхэд зардалд 450.0 сая төгрөг зарцуулахаар баталж, гүйцэтгэлээр 123.0 сая төгрөгийг зарцуулж, 327.0 сая төгрөг нь зарцуулагдаагүй царцаасан байна. Зарцуулалтыг авч үзвэл:

- Малын гоц халдварт шүлхий өвчин гарсантай холбогдуулан хариу арга хэмжээ авах зардалд 54.7 сая төгрөг,
- Байгалийн аюулт үзэгдлийн улмаас зам даваа эвдрэх, хохирлыг арилгахад 24.9 сая төгрөг,
- Онцгой комиссын гишүүдийн хувцасны зардалд 12.9 сая төгрөг
- Гамшгаас хамгаалах команд штабын иж бүрэн сургуулилалт зохион байгуулахад 22.9 сая төгрөг ,
- Байгалийн гамшиг өртөг гэргүй болсон өрхүүдэд гэр олгосонтой холбоотой тээврийн зардалд 4.5 сая төгрөг,
- Өвөлжилтийн бэлтгэл ажлыг шалгах комисс сумдад ажиллахад 3.1 сая төгрөгийг зарцуулжээ.

2.3 ТӨРИЙН ХЭМНЭЛТИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЛААР:

Архангай аймаг дахь Төрийн аудитын газар нь аймгийн ТЕЗ, ЗДТГ-ын СТСХ-тэй хамтран Төрийн хэмнэлтийн хуулийг танилцуулах, хэрэгжилтийг хангахад анхаарах асуудлын талаарх сургалт зөвлөгөөнийг аймгийн хэмжээнд 2022 оны 5 дугаар сарын 19-нөөс 5 дугаар сарын 23-ны өдрүүдэд 4 бүс болгон зохион байгуулж төсөв захирагч, санхүү



бүртгэлийн нийт 264 албан хаагчийн хамруулсан. Сургалт, зөвлөгөөний үеэр Төрийн аудитын газраас 2022 онд хэрэгжүүлсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлт, илэрсэн алдаа, зөрчлийг товч танилцуулж, төсөв захирагч, нягтлан бодогч нарт цаашид анхаарах асуудлын талаар зөвлөгөө өгсөн.

Төрийн аудитын газраас төсвийн тодотголыг шалгаж хүргүүлсэн зөвлөмжийн дагуу аймгийн засаг даргын нөөц хөрөнгийн **599.1** сая, төсөв захирагчид хуваарилаагүй тогтмол зардал **472.3** сая, гамшгаас хамгаалах зардлаас **150.0** сая, Хайрхан сумын санхүүгийн дэмжлэгээс **150.0** сая, нийт **1,371.4** сая төгрөгийн санхүүжилтийг царцааж, хэмнэлтийг бий болгож ажиллалаа.

“Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавих бодлого, чиглэл”-ийг МУЕА-ын 2022 оны 07 дугаар сарын 19-ны өдрийн А/59 дүгээр тушаалаар, “Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавих, чиглэлийг хэрэгжүүлэх заавар”-ыг МУЕА-ын 2022 оны 11 дүгээр сарын 25-ны А/89 дүгээр тушаалаар баталж, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг хянасан.

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавих бодлого, чиглэлийн дагуу ТЕЗ-ийн харьяа байгууллагуудын санхүүгийн тайлангийн аудитаар шалгахад **21** байгууллагатай холбоотой **124.5** сая төгрөгийн дараах зөрчил илэрсэн. Үүнд:

- **Хуулийн 5.2, 5.3 дахь заалт**, Засгийн газрын 2022 оны 05 дугаар сарын 25-ны өдрийн “Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлж зарим арга хэмжээний тухай” 203 дугаар тогтоолын 1 дүгээр зүйлийн 1.1 дэх заалтуудыг зөрчиж Аймгийн Засаг дарга нь хоёр орлогч, хоёр зөвлөхтэй ажиллаж нийт 19.7 сая төгрөгийн цалингийн зардал гаргасан, бүтэц орон тоо, чиг үүргийг давхардуулан баталж, ажилтан авч ажиллуулан тус ажилтанд нийт 7.9 сая төгрөгийг олгосон,
- **Хуулийн 15.1.3 дахь заалтыг** зөрчиж Чулуут, Тариат, Цахир, Өндөр-Улаан, Хотонт, Хашаат, Цэнхэр, Төвшрүүлэх, Эрдэнэмандал, Жаргалант, Цэцэрлэг, Хайрхан сумдын ЗДТГ, Цэцэрлэг, Төвшрүүлэх сумын ИТХ-ын төсвөөс нийт 43.7 сая төгрөгийг шагнал, урамшуулал, бэлэг дурсгал, хүндэтгэл үзүүлэх, тэмцээний уралдааны зардалд үр ашиггүй зардал гаргасан.
- **Хуулийн 15.2.3 дахь заалтыг** зөрчиж Төвшрүүлэх сумын ИТХ-аас сургалт семинар хурал зөвлөгөөнийг зохион байгуулахад 9.5 сая төгрөг, Ар-Ус Ундарга ОНӨХХК зочин төлөөлөгч хүлээн авах, сургалт семинарын зардалд 6.1 сая төгрөг тус тус зарцуулсан байна.
- **Хуулийн 15.2.6 дахь заалтыг** зөрчиж Тайлант онд "Архангай орон сууц корпораци" орон нутгийн өмчит ХХК-ийг иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 01 дүгээр сарын 18-ны өдрийн 12 дугаар тогтоолоор байгуулсан бөгөөд аймгийн засаг даргын 2022 оны 02 дугаар сарын 16-ны өдрийн А/109 дүгээр захирамжаар "Архангай орон сууц корпораци" орон нутгийн өмчит ХХК-ний үйл ажиллагаанд аймгийн засаг даргын нөөц хөрөнгөөс 33.5 сая төгрөгийн дэмжлэг олгосон байна. "Архангай орон сууц корпораци" орон нутгийн өмчит ХХК нь өөрийн орлого төвлөрүүлээгүй, ашиггүй ажилласан байна.
- **Хуулийн 15.2.5 дахь заалтыг** зөрчиж Архангайд үйлдвэрлэв ОНӨААТҮГ нь тайлант хугацаанд цалин, татварын тооцооллоор 3.8 сая төгрөгийн өр төлбөр үүсгэсэн,

- **Хуулийн 9.3 дахь заалтыг** зөрчиж шатны баримтыг үндэслэлгүйгээр 0.3 сая төгрөгийн томилолтын зардал олгосон зэрэг зөрчлүүд гарсан байна.

Аудитаар илэрсэн дээрх зөрчлөөс **123.5** сая төгрөгийн зөрчлийг арилгах, таслан зогсоох 19 албан шаардлага, **1.0** сая төгрөгийг төсөвт буцаан төлүүлэх 2 төлбөрийн акт тогтоон ажиллалаа.

Цаашид Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг хангуулан ажиллахад аймгийн ТЕЗ-ийн зүгээс зохион байгуулалтын арга хэмжээг авч шаардлагатай гэж үзлээ.

Санал: Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавих, горим арга зүйг аудитад ашиглахад хуулийн 6 дугаар зүйл Тээврийн хэрэгсэлтэй холбоотой заалтыг орон нутагт мөрдөн ажиллахад хүндрэлтэй байлаа. Үүнд:

6.2 ... аймаг сум, нийслэл дүүргийн ИТХ-ын дарга, Засаг даргаас бусад этгээд албан тушаалын суудлын авто машин ашиглахыг хориглоно гэсэн заалт нь хөдөө орон нутагт ялангуяа сумдын ЗДТГ нь 1 автомашинтай төрийн бүхий л ажилд ашиглагддаг тул энэхүү заалт нь хэрэгжихэд хүндрэлтэй байна.

6.4 Төрийн болон орон нутгийн өмчид бүртгэлтэй бүх төрлийн авто тээврийн хэрэгсэлд бусад авто тээврийн хэрэгслээс ялгагдах тод дэвсгэр өнгө бүхий улсын дугаар хэрэглэнэ гэсэн заалт нь Улсын хэмжээнд хэрэгжиж эхлээгүй байгаатай холбоотой мөрдөгдөөгүй байна.

БҮЛЭГ 3: АЙМГИЙН ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧИЙН САЙДУУДАЙ БАЙГУУЛСАН ГЭРЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТ ҮНЭЛГЭЭНИЙ ДУНДЖААР 90.9 ХУВЬТАЙ БАЙНА.

3.1 Аймгийн ТЕЗ-ийн хөтөлбөрийн хэрэгжилт:

Төсвийн ерөнхийлөн захирагчийн яамдын сайдуудтай байгуулсан гэрээний биелэлтийг жилийн эцсийн гүйцэтгэлээр авч үзэхэд сайдуудаас ирүүлсэн үнэлгээний дунджаар гэрээний хэрэгжилт 90.9 хувьтай дүгнэгджээ.

Хүснэгт: 11 Аймгийн ТЕЗ-ийн сайдуудтай байгуулсан гэрээний хэрэгжилт

№	Сайдын нэр	Арга хэмжээийн тоо	Биелэлтийн явц							Хугацаа болгоогүй, үнэлэх боломжгүй	Биелэлтийн дундаж хувь
			Үүний дотор								
			100%	90%	70%	50%	30%	0%			
1	Монгол Улсын Шадар сайд	37	28	3	1	2	3	-	-	90	
2	Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга	25	17	1	7	-	-	-	-	91.2	
3	Байгаль орчин, аялал жуулчлалын сайд	52	26	4	7	9	2	-	4	82.3	
4	Сангийн сайд	44	36	3	4	-	-	-	1	96.5	
5	Хууль зүйн сайд	22	19	2	-	-	1	-	-	95.9	

**АРХАНГАЙ АЙМГИЙН ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧИЙН
2022 ОНЫ НЭГДСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН**

6	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд	51	35	11	5	-	-	-	-	95.1
7	Батлан хамгаалахын сайд	32	25	4	1	-	-	-	2	97.1
8	Барилга, хот байгуулалтын сайд	103	25	39	23	8	4	-	4	82.2
9	Боловсрол, шинжлэх ухааны сайд	70	58	7	4	1	-	-		96.5
10	Соёлын сайд	50	33	5	3	3	-	2	4	89.2
11	Зам, тээврийн хөгжлийн сайд	38	30	-	8	-	-	-	-	90
12	Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд	30	16	9	-	-	-	-	5	96.5
13	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд	70	38	17	14	-	1	-	-	90.5
14	Эрчим хүчний сайд	14	3	6	4	-	-	-	1	86.1
15	Эрүүл мэндийн сайд	74	33	31	7				3	92.6
16	Эдийн засаг, хөгжлийн сайд	9	8	1	-	-	-	-	-	98.6
17	Цахим хөгжил, харилцаа холбооны сайд	28	22	-	-	4	2	-	-	87.8
18	Гадаад харилцааны сайд	10	6	1	-	-	-	1	2	86.2
Нийт арга хэмжээний тоо, хувь		756	455	144	88	27	13	3	26	90.9

Архангай аймгийн төсвийн ерөнхийлөн захирагч нь 2022 онд нийт 756 заалт бүхий арга хэмжээг хэрэгжүүлж ажиллахаас 455 арга хэмжээг бүрэн буюу 100 хувь, 144 арга хэмжээний үр дүн гарч эхэлсэн буюу 90 хувь, 88 арга хэмжээ хэрэгжих шатанд буюу 70 хувь, 27 арга хэмжээ 50 хувь, 13 арга хэмжээ хэрэгжилт хангалтгүй буюу 30 хувь, 3 арга хэмжээ хэрэгжээгүй, 26 арга хэмжээний хэрэгжих хугацаа болоогүй байна.

БҮЛЭГ 4. ТАЙЛАНТ ОНД 2,080.1 САЯ ТӨГРӨГИЙН НЭМЭЛТ САНХҮҮЖИЛТ АВЧ ЗАРЦУУЛСАН БАЙНА.

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд аймгийн ТЕЗ-ийн харьяа байгууллагууд нэмэлт санхүүжилтээр 2,080.2 сая төгрөгийг хүлээн авч, цалин, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлийн зардалд 66.4 сая, хангамж, бараа материалын зардалд 33.9 сая, нормативт зардалд 2.2 сая, эд хогшил, урсгал засварын зардалд 41.8 сая, албан томилолтын зардалд 16.1 сая, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөрт 324.1 сая, бараа үйлчилгээний бусад зардалд 1,048.8 сая, урсгал шилжүүлэгт 188.8 сая, хөрөнгийн зардалд 357.9 сая нийт **2,080.1** сая төгрөгийг зарцуулсан байна.

Нийт санхүүжилтийн **1,982.5** сая төгрөгийг орон нутгийн төсөвт байгууллагуудын, **97.6** сая төгрөгийг эрүүл мэндийн салбарын байгууллагуудын урьд оны үлдэгдлээс зарцуулсантай холбоотой байна.

БҮЛЭГ 5. АЙМГИЙН САНХҮҮ, ТӨРИЙН САНГИЙН ХЭЛТЭС ӨМНӨХ ОНЫ АУДИТААР ӨГСӨН ЗӨВЛӨМЖИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ТАЛААР ТОДОРХОЙ АРГА ХЭМЖЭЭ АВЧ АЖИЛЛАСАН Ч ЗӨРЧИЛ ДАВТАГДСААР БАЙНА.

Аймгийн ТЕЗ-ийн 2021 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн аудитаар нийт **4,648.7** сая төгрөгийн зөрчил илэрсэнд аудитаас зөрчлийг арилгах, таслан зогсоох, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах чиглэлээр 1 албан шаардлага, 3 заалт бүхий зөвлөмж өгсөн бөгөөд хэрэгжилтийг аймгийн ЗДТГ-ын 2022 оны 11 дүгээр сарын 01-ний 08/1770, 2022 оны 11 дүгээр сарын 23-ны 08/1876 тоот албан бичгүүдээр гаргаж ирүүлсэн. Өмнөх оны аудитаар өгсөн шийдвэрийн биелэлтийг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт: 12 зөвлөмжийн биелэлт

	Өгсөн зөвлөмж	Байгууллагаас ирүүлсэн албан бичгийн утга, биелэлт	
Аймгийн Засаг дарга, төсвийн ерөнхийлөн захирагч М.Батжаргал, Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга Ж.Мөнхбат нарт			
1	Тасарч байгаа нэр төрлийн орлогуудад судалгаа, дүгнэлт хийж орлогыг бодитой төлөвлөн, төлөвлөгөөг нэр төрөл тус бүрээр биелүүлэхэд анхаарч орлогын төлөвлөлт, гүйцэтгэлд хяналт тавьж ажиллах	Байгууллагаас ирүүлсэн биелэлт, хариу	Орон нутгийн төсвийн орлогын төлөвлөгөөг жигд ханган биелүүлэх талаар сумдын засаг дарга нарын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд заалт болгон оруулж, холбогдох арга хэмжээг авч, 2 ажлын хэсэг байгуулан сумдад удирдамж чиглэл өгч ажилласан ч Сангийн Яамнаас зарим нэр төрлийн орлогыг өмнөх оны гүйцэтгэлд үндэслэхгүйгээр хэт өндрөөр хянаж байгаа тул орлогыг нэр төрлөөр жигд ханган биелүүлэхэд хүндрэл учирч байна.
		Аудитаар тооцсон биелэлт	Аудитаар 4 нэр төрлийн орлого буюу шууд бус орлого, галт зэвсгийн албан татвар, улсын тэмдэгтийн хураамж, байгалийн ургамал ашигласны төлбөрийн орлогууд тасарсанд тухан нөхцөл байдлыг үнэлж аудитаас зөвлөмж хүргүүлэн ажилласан байна. Тайлант онд дээрх 3 нэр төрлийн орлогоос гадна 6 нэр төрлийн орлого тасарсан тул биелэлт хангалтгүй гэж байна гэж үзлээ. Биелэлт 20%
2	Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.10-т/ өөрийн эрхлэх асуудлын хүрээнд дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх/ заасны дагуу хүрээнд төсвийн зарцуулалтад тавих Төрийн сангийн болон төсөв захирагчдын дотоод хяналтыг сайжруулах арга хэмжээг авч ажиллах	Байгууллагаас ирүүлсэн биелэлт, хариу	Төрийн сангийн төлбөр тооцооны дотоод хяналтын жилийн төлөвлөгөөг аймгийн засаг даргын А/82 дугаар захирамжаар батлуулан хэрэгжилтийг ханган өдөр тутмын гүйлгээнд хяналт тавьж ажиллаж байна. Баруун болон зүүн хойд бүсийн сумд 2022.10.28-наас аймгийн засаг даргын орлогчоор батлуулсан удирдамжийн дагуу хяналт хийж зөвлөн туслах үйлчилгээг үзүүлж ажилласан. Мөн Эрхийн бүртгэл, ТАЦНС-ээр цахим гүйлгээ хийхтэй холбоотой "Finance.gov.mn , Payroll.mn системд 1,2-р гарын үсэг зурах эрх бүхий албан хаагчдын мэдээллийг бүртгэлжүүлэн баримт бичгийн тохиргоо хийж баталгаажуулан хяналтыг хэрэгжүүлэн цаг тухай бүрд нь заавар зөвлөгөөг өгч, системийн хөгжүүлэлт сайжруулалтын талаарх сургалтыг хийсэн.

**АРХАНГАЙ АЙМГИЙН ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧИЙН
2022 ОНЫ НЭГДСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН**

		Аудитаар тооцсон биелэлт	ТШЗ-ийн 2022 оны санхүүгийн тайлангийн аудитаар нийт 19 байгууллагатай холбоотой 205.7 сая төгрөгийн Сангийн сайдын 2021 оны 10 дугаар 29-ны 190 дүгээр тушаалаар баталсан "Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар"-ыг зөрчсөн, төсөвт зохицуулалт хийлгүйгээр зориулалт бус зарцуулсан зэрэг зөрчил млэрсэн тул зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлээгүй гэж үзлээ. Биелэлт 70%
3	Төсвийн тухай хуулийн 65 дугаар зүйлийн 65.1.8-д /тухай шатны төсвийн байгууллагын орон тоог төсөв захирагч бүрээр батлах / заасны дагуу төсвийн байгууллагын орон тоог жишиг норм, стандартыг баримтлан төсвийн захирагч бүрээр батлуулан хяналт тавьж ажиллах	Байгууллагаас ирүүлсэн биелэлт, хариу	Монгол улсын Засгийн газрын 2021 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн 377 дугаар тогтоолоор засаг даргын тамгын газрын бүтэц орон тоог, 376 дугаар тогтоолоор аймгийн ИТХ-ын ажлын алба, сумдын ИТХ-ын ажлын албаны бүтэц орон тооны хязгаарыг баталсны хүрээнд аймгийн засаг даргын захирамж, чиглэл хүргүүлэн ажиллаж байна.
		Аудитаар тооцсон биелэлт	ТШЗ-ийн санхүүгийн тайлангийн аудитаар орон тоо бүтцийг хянахад ЗГ-ын 376,377 дугаар тогтоолуудыг мөрдөн аймаг, сумдын ЗДТГ, ИТХ-ын орон тоо бүтцийг шинэчлэн баталж ажилласан байна. Биелэлт 90%
4	Аудитаар тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагуудын төсөвт орсон төсвийн зохицуулалтыг сумдын ИТХ-ын тогтоолд тусгаагүйгээс 4,394.6 сая төгрөгийг зөрчил илэрсэнд зөрчлийг таслан зогсоож, төсөвт орсон өөрчлөлтийг сумын ИТХ-аар баталж байх	Байгууллагаас ирүүлсэн тайлбар	Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2022 оны төсвийн төслийг төсвийн хууль, журам аргачлалд заасны дагуу боловсруулан аймгийн ИТХ-аар хэлэлцүүлэн батлуулж ажилласан. Мөн 2022 оны төсөв, тодотгосон төсвийн талаар анхаарч ажиллах чиглэлийг албан бичгээр сумдад хүргүүлэн зөрчлийг таслан зогсоож ажиллалаа.
		Аудитаар тооцсон биелэлт	Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны санхүүгийн тайлангийн аудитаар сумдын ИТХ-ыг тулган шалгахад тус зөрчил илрээгүй тул албан шаардлагыг хэрэгжүүлэн ажилласан байна дүгнэлээ. Биелэлт 100%
			БИЕЛЭЛТИЙН ДУНДАЖ ХУВЬ 70%

БҮЛЭГ 6: ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧИЙН НЭГДСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

1. Төсвийн гүйцэтгэлийн тайланд сумдад олгох татаас 9,370.8 сая төгрөг, Эрдэнэбулган сумаас аймагт төвлөрүүлсэн орлого 1,317.2 сая төгрөг, нийт **10,688.0** сая төгрөгийг давхардуулан бүртгэж тайлагнасныг төсвийн гүйцэтгэлийн тайлангийн төлөвлөгөө, гүйцэтгэлийг бууруулж залруулга хийлгэлээ.
2. 2022 оны төсвийн тодотголыг хянаж үзэхэд Сангийн яамнаас нийт зардлыг 4,771.4 сая төгрөгөөр хасаж, аймгийн ЗДТГ-ын ТҮ1-ТҮ3 хүртэлх цалинтай албан хаагчдын цалин, НДШ-ийг 162.0 сая төгрөгөөр нэмж тодотгохоор хянасан байхад аймгийн ИТХ-ын 2022 оны 11 дүгээр тогтоолоор баталсан нийт зардлын дүнг

анх баталсан дүнтэй харьцуулахад 7 нэрийн зардлын дүнг 5,420.9 сая төгрөгөөр бууруулж, 11 нэрийн зардлыг 1,951.7 сая төгрөгөөр нэмэгдүүлэн нийт зардлын дүнг 3,469.2 сая төгрөгөөр бууруулж баталсан. Өөрөөр хэлбэл Сангийн яамны хянасан дүнгээс **1,302.2** сая төгрөгөөр зардлын нэмэгдүүлсэн байна.

Аймгийн ИТХ-ын 2022 оны 11 дүгээр тогтоолоор урьд оны үлдэгдлээс санхүүжүүлэхээр тооцож тодорхой нэр төрлийн урсгал зардлуудын дүнг нэмэгдүүлсэн асуудал нь төсөвт тодотгол хийх гол шалтгаанаас гажсан, “санхүүгийн сахилга батыг мөрдүүлж, ил тод байдлыг хангах, үр ашгийг нэмэгдүүлэх, үрэлгэн байдлыг хязгаарлах...” Төрийн хэмнэлтийн тухай хуулийн зорилготой нийцээгүй бөгөөд холбогдох хуулийн хэрэгжилтийг хангаагүй байна.

Иймд аудитаас Төсвийн тухай хууль болон Төрийн хэмнэлтийн тухай хуулийг мөрдөн, төсвийн тодотголыг төсвийн тодотгол хийх гол үзэл баримтлалын дагуу хийж байх зөвлөмжийг хүргүүллээ.

3. Аймгийн ТЕЗ-ийн 2022 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлээр 9 нэр төрлийн орлогын төлөвлөгөө нийт 2,024.2 сая төгрөгөөр тасарсан бөгөөд үүнээс 695.4 сая төгрөгийг бүрэн төвлөрүүлэх боломжтой байсан байна.

Иймд Орон нутгийн төсвийн орлогын төлөвлөгөөг орлогын нэр төрөл бүр дээр дүн шинжилгээ хийж, биелэгдэхүйц бодит тоон мэдээ судалгаанд үндэслэн төлөвлөж, нэр төрлөөр жигд ханган биелүүлэхэд анхаарч ажиллах зөвлөмж хүргүүллээ.

4. Төсвийн шууд захирагчдын санхүүгийн тайлангийн аудитаар **19** байгууллага Сангийн сайдын 2021 оны 10 дугаар 29-ны 190 дүгээр тушаалаар баталсан "Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар"-ыг зөрчиж, төсөвт зохицуулалт хийлгүйгээр төсвийг зориулалт бус зарцуулсан **205.7** сая төгрөгийн зөрчил илэрсэн байна. Үүнд:

- БОАЖГ -Байгаль хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний зардлаас 77.7 сая төгрөгийн үндсэн хөрөнгө бэлтгэсэн,
- Булган сумын ЗДТГ- Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх зардлаас сэлбэгийн зардалд 8.0 сая төгрөгийн автомашины сэлбэг худалдан авсан,
- Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардлаас Ихтамир сумын сум дундын ойн анги 10.0 сая, Цэнхэр сумын сум дундын ойн анги 7.5 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг тус тус бэлтгэсэн,
- Цахир сумын ЗДТГ нь түүх соёлын дурсгалт зүйлийг хамгаалах арга хэмжээний зардлаас ахмадын байгууллагыг дэмжих үйл ажиллагааны зардалд 4.0 сая төгрөгийг зарцуулсан,
- Ихтамир сумын ЗДТГ нь бараа үйлчилгээний бусад зардлаас өмгөөлөгчийн хөлсөнд 6.8 сая төгрөгийг зарцуулсан,
- Төвшрүүлэх сумын ИТХ нь хичээл үйлдвэрлэлийн зардлаас 17.3 сая төгрөгийг төлөөлөгчдөд тэтгэмж урамшуулал олгосон,
- Нэг удаагийн тэтгэмж урамшууллын зардлаас Хайрхан сумын ИТХ нь сургалтын зардалд 1.0 сая төгрөг, Өндөр-Улаан сумын ИТХ тэмцээний шагналын зардалд 1.0 сая төгрөг, Төвшрүүлэх сумын ЗДТГ- хөрөнгө

худалдан авахад 8.0 сая төгрөг, Хотонт сумын ЗДТГ нь туршлага судлах, сургалтын зардалд 1.0 сая төгрөгийг тус тус зарцуулсан

- **"Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар"**-ыг зөрчиж бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардлаас Хайрхан сумын ЗДТГ нь хог тээврийн машины шатахуунд 5.5 сая төгрөг, хогны машины жолооч, ачигчийн цалин, шимтгэлийн зардалд 6.9 сая төгрөгийг, Цахир сумын ЗДТГ шүтээний харуул хамгаалалтын ажилтны цалин, шимтгэлийн зардалд 5.6 сая төгрөгийг, Эрдэнэбулган сумын ИТХ нь олон нийтийн цагдаагийн цалин, шимтгэлийн зардалд 10.7 сая төгрөгийг, Жаргалант сумын ЗДТГ хогийн цэгийн манаач, хог тээврийн автомашины жолооч нарын цалин, шимтгэлийн зардалд 8.7 сая төгрөгийг, Цэнхэр сумын ИТХ олон нийтийн цагдаагийн цалин, шимтгэлийн зардалд 5.7 сая төгрөгийг тус тус зарцуулсан байна.
- **"Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар"**-ыг зөрчиж хог хаягдлыг зайлуулах, хортон мэрэгчдийн устгал ариутгал хийх зардлаас хог тээврийн автомашины жолоочийн цалин, шимтгэлийн зардалд Эрдэнэмандал сумын ЗДТГ 10.4 сая төгрөгийг, Цэнхэр сумын ЗДТГ нь 5.7 сая төгрөгийг, Хангай сумын ЗДТГ 4.2 сая төгрөгийг тус тус зарцуулсан байна.

Иймд аудитаас Төсвийн Ерөнхийлөн захирагчийн зүгээс аймгийн бүх шатны төсөв захирагчдын төсөв санхүүгийн сахилга батыг сайжруулан, хяналтыг хэрэгжүүлж, зөрчлийг арилгах арга хэмжээ авч ажиллах зөвлөмжийг хүргүүллээ.

5. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавих бодлого, чиглэлийн дагуу ТЕЗ-ийн харьяа байгууллагуудын санхүүгийн тайлангийн аудитаар шалгахад **21** байгууллагатай холбоотой **124.5** сая төгрөгийн зөрчил илэрч **123.5** сая төгрөгийн зөрчлийг арилгах, таслан зогсоох 19 албан шаардлага, **1.0** сая төгрөгийг төсөвт буцаан төлүүлэх 2 төлбөрийн акт тогтоон ажиллалаа.

Иймд цаашид Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг хангуулан ажиллахад аймгийн ТЕЗ-ийн зүгээс зохион байгуулалтын арга хэмжээг авч зөвлөмжийг хүргүүллээ.

АУДИТЫН ДҮГНЭЛТ

Нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн аудитаар нийт **12,891.3** сая төгрөгийн алдаа зөрчил илэрч, аудитын явцад **10,688.0** сая төгрөгийн алдааг залруулж, **2,203.3** сая төгрөгийн зөрчил илэрсэнд хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулан ажиллах, дотоод хяналтыг сайжруулах талаар 4 заалт бүхий зөвлөмжийг аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүллээ.

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна.

- Сангийн яамнаас аймгийн 2022 оны төсвийн жилийн суурь орлогыг 2,117.6 сая төгрөгөөр нэмэгдүүлэн, орон нутгийн суурь зарлагыг 2,255.1 сая төгрөгөөр бууруулан 33,022.3 сая төгрөгөөр хянажээ.
- Төсвийн орлогын төлөвлөгөөг 116.0% буюу 2,525.2 сая төгрөгөөр давуулан биелүүлсэн байна.
- Төсвийн зарлагын гүйцэтгэл 81.7 хувьтай байна.

- Аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн сайдуудтай байгуулсан гэрээний хэрэгжилт үнэлгээний дунджаар 90.9 хувьтай байна.
- Тайлант онд 2,080.1 сая төгрөгийн нэмэлт санхүүжилтийг зарцуулсан байна.
- Аймгийн санхүү, төрийн сангийн хэлтэс өмнөх оны аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэх талаар холбогдох арга хэмжээг авч ажилласан ч зөрчлүүд бүрэн арилаагүй, давтагдсаар байна.
- Аймгийн 2022 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлээр 41,443.3 сая төгрөгийн нийт орлого ба тусламж, 42,228.6 сая төгрөгийн нийт зарлага ба зээлийн дүнг баталгаажууллаа.
- Архангай аймаг дахь Төрийн аудитын газраас зохион байгуулсан бүсчилсэн сургалт, төсвийн тодотголтой холбоотой зарим зардлуудыг царцаасны дүнд нийт 1,371.4 сая төгрөгийн төсвийн бодит хэмнэлтийг бий болголоо.

АУДИТЫН ЗӨВЛӨМЖ

Аудитын дүнд үндэслэн холбогдох албан тушаалтанд дараах зөвлөмжийг хүргүүлж байна.

Аймгийн Засаг дарга Б.Цэрэннадмид, СТСХ-ийн дарга Ж.Мөнхбат нарт :

- ✓ Төрийн хэмнэлтийн хуулийг баримтлан, тайлангийн жилд төсөвт тодотгол хийхдээ Сангийн яамнаас ирүүлсэн төсвийн удирдамжийг баримтлах
- ✓ Орон нутгийн төсвийн орлого тасарч байгаа шалтгаан нөхцөлийг судалж, дүгнэлт хийн, төлөвлөлтөд анхаарч, гүйцэтгэлд тавих хяналтыг сайжруулж, төлөвлөгөөг нэр төрөл тус бүрээр биелүүлэх арга хэмжээ авах
- ✓ Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.10-т “өөрийн эрхлэх асуудлын хүрээнд дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх” заалтын дагуу төсөв захирагч нарын төсвийн зарцуулалтад тавих Төрийн сангийн болон төсөв захирагчдын дотоод хяналтыг сайжруулах арга хэмжээ авах
- ✓ Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг хангуулан ажиллахад аймгийн ТЕЗ-ийн зүгээс зохион байгуулалтын арга хэмжээг авч ажиллах

Зөвлөмжийн биелэлтийг 2023 оны 12 дугаар сарын 01-ний дотор багтаан Архангай аймгийн Төрийн аудитын газарт ирүүлэх

УЛАМЖЛАХ САНАЛ

Орон нутгийн 2022 оны орлогын төлөвлөлт, гүйцэтгэлээр аймгийн шууд бус орлого болон ААН-ийн орлогын албан татварын орлогууд төлөвлөгөөнөөс 42%-71.2%-иар тасарсанд аймгийн Санхүү Төрийн сангийн хэлтэс болон Татварын хэлтсээс Сангийн яамнаас өмнөх оны гүйцэтгэлд үндэслэн хяналгүйгээр хэт өндрөөр төлөвлөж ирүүлсэн нь орлого тасрах гол шалтгаан болсон гэсэн тайлбарыг ирүүлээд байна.

Иймд орон нутгаас хүргүүлсэн төсвийн орлогын саналыг харгалзан орлогыг хянаж байх саналыг Сангийн яаманд уламжилж байна.

АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/сая төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Аймгийн ТЕЗ	1	10688.0	0	0	1	10688.0	1	10688.0	0	0	0	0

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Аймгийн ТЕЗ	4	2203.3	0	0	0	0	4	2203.3	0	0	0	0

**АРХАНГАЙ АЙМГИЙН ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧИЙН
2022 ОНЫ НЭГДСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН**

Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/ мянган төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	51,675,343.7	42,228,586.8	9,446,756.9	81.7
21	УРСГАЛ ЗАРДАЛ	32,027,852.2	29,120,761.0	2,907,091.2	90.9
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	30,101,826.3	27,271,164.0	2,830,662.3	90.6
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	10,895,124.9	10,512,031.7	383,093.2	96.5
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	1,366,333.0	1,298,582.8	67,750.2	95.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	8,594,385.5	7,740,130.4	854,255.1	90.1
2104	Хангамж, бараа материалын зардал	874,079.1	848,101.4	25,977.7	97.0
2105	Нормативт зардал	8,000.0	7,351.0	649.0	91.9
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	982,881.6	936,525.0	46,356.6	95.3
2107	Томилолт, зочны зардал	137,200.1	128,326.1	8,874.0	93.5
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,270,804.9	3,006,672.3	264,132.6	91.9
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	3,973,017.2	2,793,443.2	1,179,574.0	70.3
212	ТАТААС	107,994.1	89,186.5	18,807.6	82.6
2121	Төрийн өмчит байгууллагад олгох татаас	18,800.0	0.00	18,800.0	-
2122	Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас	89,194.1	89,186.5	7.6	100.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,818,031.8	1,760,410.5	57,621.3	96.8
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	588,120.0	588,120.0	-	100.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,229,911.8	1,172,290.5	57,621.3	95.3
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	15,619,697.7	10,522,722.0	5,096,975.7	67.4
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	4,027,793.8	2,585,103.8	1,442,690.0	64.2
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	51,675,343.7	41,443,336.6	10,232,007.1	80.2
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	37,541,916.8	38,875,472.8	(1,333,556.0)	103.6
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	14,133,426.9	2,567,863.8	11,565,563.1	18.2
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	5,584,877.2	(5,584,877.2)	-
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	4,726,917.4	(4,726,917.4)	-
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	1,654	1,640	14	99.15
620001	Удирдах ажилтан	155	152	3	98.06
620002	Гүйцэтгэх ажилтан	414	436	-22	105.31
620003	Үйлчлэх ажилтан	1,056	1,036	20	98.11
620004	Гэрээт ажилтан	29	16.00	13	55.17

**АРХАНГАЙ АЙМГИЙН ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧИЙН
2022 ОНЫ НЭГДСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН**

Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/мянган төгрөгөөр/

II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,080,057.6
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,722,059.4
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,533,270.8
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	57,184.5
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	9,143.4
2104	Хангамж, бараа материалын зардал	33,959.6
2105	Нормативт зардал	2,160.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	41,792.8
2107	Томилолт, зочны зардал	16,121.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	324,098.1
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,048,811.4
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	188,788.6
2132	Бусад урсгал шилжүүлэг	54,473.8
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	134,314.8
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	357,998.2
2200	Дотоод эх үүсвэрээр	357,998.2
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,982,469.3
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	1,982,469.3
III	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)	(97,588.3)
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	97,588.3
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-